



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ТӨРӨӨС ЭМИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ ҮР НӨЛӨӨ”

ТӨРӨӨС ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ЧИГЛЭЛЭЭР БАРИМТЛАХ БОДЛОГЫН
ХЭРЭГЖИЛТИЙГ САЙЖРУУЛЖ, ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

Аудитын код: ДГА-2021/14-9-ШТА-ГА

Цахим хуудас:

www.audit.mn

Дорноговь аймаг

2021 оны 11 сар

Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 70522734

Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn

Аудитын менежер:

У.Оюунтүлхүүр

Утас: 70523020

Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Аудитор:

Ч.Хэрлэнчимэг

Цахим хаяг: kherlenchimegch@audit.gov.mn

Аудитор:

Б.Ариунбаатар

Цахим хаяг: ariunbaatarb@audit.gov.mn

Гэрээт аудитор

М.Дүүрэнжаргал

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ТАЙЛАНГИЙН АГУУЛГА	
<u>Тайланг бэлтгэсэн:</u>	Агуулга 2
Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газар	Товчилсон үгийн тайлбар 3
	Хүснэгтийн товъёог 4
Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий	Дүрслэлийн товъёог 4
	Зургийн товъёог 4
	Хавсралтын товъёог 4
Аудитын менежер: У.Оюунтүлхүүр	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй 5-6
	Ерөнхий мэдээлэл 7-8
Аудитор: Ч.Хэрлэнчимэг	БҮЛЭГ А. ТӨРӨӨС ЭМИЙН ЧИГЛЭЛЭЭР БАРИМТЛАХ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙГАА НЬ ЭМИЙН ХАНГАЛТ, ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДАЛД СӨРГӨӨР НӨЛӨӨЛӨХ ЭРСДЭЛТЭЙ БАЙНА.
Аудитор: Б.Ариунбаатар	А.1. Төрөөс эм, эмнэлгийн хэрэгслээр хангах бодлогын хэрэгжилтийн үр дүнг сайжруулах шаардлагатай байна. 9-14
Гэрээт аудитор: М.Дүүрэнжаргал	А.2. Улсын төсвөөс олгох эмийн санхүүжилтийг нэмэгдүүлэх шаардлагатай байна. 14-17
2021 оны 11 сарын 04	А.3. Эмзүйн салбарын хүний нөөцийг бэлтгэх бодлого бүрэн хэрэгжихгүй байдлаас хүний нөөцийн дутагдал үүсч, эмийн хяналтын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлсөн байна. 17-22
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70522734, 70503020 дугаарын утас, dornogovi@audit.gov.mn хаягаар харилцана уу.	БҮЛЭГ Б. ТӨРӨӨС ЭРҮҮЛ МЭНДИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ БОЛОН ЭМИЙН ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭГ ТӨЛӨВШҮҮЛЭХ АЖЛЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.
	Б.1 Төрөөс эмийн талаар баримтлах бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх бодлогын баримт бичгийг боловсруулж, хэрэгжүүлсэн боловч хэрэгжилтийг үнэлээгүй байна. 22-24
	Б.2 Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх ажил хийгддэг боловч үр дүн хангалтгүй, мэргэжлийн хүний нөөц дутагдалтай байна. 24-29
Хаяг:	Аудитын дүгнэлт 30
Дорноговь аймаг, Сайншанд сум, Орон нутгийн өмчийн III байр.	Аудитын зөвлөмж 31
	Тайлангийн хавсралтууд
	Холбогдох байгууллагын санал 32-33

Товчилсон үгийн тайлбар

МУ	Монгол Улс
УИХ	Улсын Их Хурал
ЗГ	Засгийн газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ИТХТ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчид
АЗДТГ	Аймгийн засаг даргын тамгын газар
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ЭМСС	Эрүүл мэнд, спортын сайд
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТАБ	Төрийн аудитын байгууллага
ТАЗ	Төрийн албаны зөвлөл
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭМД	Эрүүл мэндийн даатгал
ЭМДҮЗ	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМДХ	Эрүүл мэндийн даатгалын хэлтэс
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЭЭЗХ	Эмийн эмчилгээг зохицуулах хороо
ЭЭС	Эм эргэлтийн сан
АШУУИС	Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЗШЭ	Зайлшгүй шаардлагатай эм
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
БИБ	Биологийн идэвхт бүтээгдэхүүн
УАУРСТ	Уламжлалт анагаах ухаан рашаан сувиллын төв
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ЭХНБ	Эм ханган нийлүүлэх байгууллага

Хүснэгтийн товъёог:

Утга	Тайлбар
Хүснэгт №1	Эм, эмнэлгийн хэрэгслийн борлуулалт, зарцуулалтын хэмжээ
Хүснэгт №2	Эрүүл мэндийн байгууллагын тоо /2020 оны байдлаар/
Хүснэгт №3	Эмийн сангийн тоо, сумдаар /2020 оны байдлаар/
Хүснэгт №4	Эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авах ажиллагааны мэдээлэл
Хүснэгт №5	Эм, эмнэлгийн хэрэгсэл бүртгэх программ хангамж
Хүснэгт №6	ЭМДС-аас олгох хөнгөлөлттэй эмийн зардлын санхүүжилт
Хүснэгт №7	Төрийн өмчит 6 эрүүл мэндийн байгууллагын эмийн зардлын санхүүжилт
Хүснэгт №8	Сумдын болон өрхийн эрүүл мэндийн төвийн эмийн зардлын санхүүжилт
Хүснэгт №9	Салбар сургуульд элсүүлэх оюутны хяналтын тоо
Хүснэгт №10	Эмийн мэргэжилтний хүний нөөцийн тоон мэдээлэл
Хүснэгт №11	Стандартын хэрэгжилтийн хяналт, шалгалтын мэдээлэл
Хүснэгт №12	Иргэдэд зориулан явуулсан сургалтын мэдээлэл

Дүрслэлийн товъёог:

Утга	Тайлбар
График №1	Асуулгын үр дүн
График №2	Эмийн зохистой хэрэглээний талаар мэдээллийн эх сурвалж, хариултын тоогоор
График №3	Эмийн зохистой хэрэглээний талаарх асуулгын дүн, хариултын тоогоор

Зургийн товъёог:

Утга	Тайлбар
Зураг №1	Licemed.mohs.mn систем
Зураг №2	Нийтийн үйлчилгээтэй эмийн сан
Зураг №3	Эмийн зохистой хэрэглээний сургалт, сурталчилгаа

Хавсралтын товъёог:

Утга	Тайлбар
Хавсралт №1	Зайлшгүй шаардлагатай эмийн хангалтын дэлгэрэнгүй жагсаалт
Хавсралт №2	Нийтийн болон эмнэлгийн эмийн сангийн хүн хүчний хангалт

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/28 дугаар тушаалаар батлагдсан аудитын төлөвлөгөөг үндэслэн “Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, үр нөлөө”-д гүйцэтгэлийн аудит хийсэн.
Аудитын зорилго	<p>Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, үр нөлөөнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж, дүнг Үндэсний аудитын газар, аймгийн Засаг дарга, аймгийн Эрүүл мэндийн газарт танилцуулж, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэгдсэн.</p> <p>Дээрх зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none">▪ Хүн амыг эмчилгээний өндөр идэвхтэй, аюулгүй, чанарын баталгаатай эм, эмнэлгийн хэрэгслээр хангах, түгээх тогтолцоо бүрдсэн эсэх;▪ Төрөөс эмийн талаар баримтлах бодлого хэрэгжсэнээр хүн амын өвчлөлт буурч, эмийн зохистой хэрэглээ төлөвшсөн эсэх.
Аудитын хамрах хүрээ	Аудитаар аймгийн Эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналтын газар, аймгийн Засаг даргын тамгын газрын холбогдох хэлтэс, эрүүл мэндийн болон эм, эмнэлгийн хэрэгслээр хангах, түгээх, худалдах эрх бүхий байгууллага, тус чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын 2018-2020 онуудын үйл ажиллагааг хамрууллаа.
Аудитын хязгаарлалт	<p>Улс даяар тархаад байгаа Ковид-19 цар тахал өвчлөлийн улмаас бүх эрүүл мэндийн болон эм хангамжийн байгууллагын үйл ажиллагааг газар дээр нь очиж шалгах боломжгүй байсан тул 4 сумын нийт 14 байгууллагын үйл ажиллагааг шалгаж, холбогдох албан тушаалтантай уулзаж, ярилцлага хийсэн.</p> <p>Мөн холбогдох албан тушаалтан Ковид-19 вирусийн халдвар авсан, гэрийн тусгаарлалтад байгаа зэрэг шалтгаанаар аудитад шаардлагатай баримт материалыг бүрэн хэмжээнд, шаардсан хугацаанд ирүүлэхгүй байсан нь аудит хугацаандаа хийгдэхгүй байх эрсдэлтэй байв.</p>
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг МУ-ын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит, тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит, Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит, Гүйцэтгэлийн аудит” стандартад заасан

**Аудит хийх багийн
бүрэлдэхүүн,
хугацаа**

зарчим, арга зүйд нийцүүлэн, МУ-ын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан “ТАБ-аас аудит хийх журам”, 2021 оны А/69 дүгээр тушаалаар батлагдсан “Заавар, аргачлал”-ыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, тодруулга авах, иргэдээс асуулга авах, тайлан баримт материалд дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглахын зэрэгцээ аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитыг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Т.Ган-Өлзий хянан удирдаж, аудитын менежер У.Оюунтүлхүүр аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлэн, аудитор Ч.Хэрлэнчимэг, аудитор Б.Ариунбаатар, гэрээт аудитор М.Дүүрэнжаргал нар гүйцэтгэв.

Аудитыг 2021 оны 09 дүгээр сарын 27-ны өдрөөс эхэлж, аудитын тайланг 10 дугаар сарын 28-ны өдрийн дотор нэгтгэн, холбогдох үе шатны хяналтаар оруулан дуусгавар болгож, дарга, тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулан, 2021 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр Үндэсний аудитын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүллээ.

Хүндрэл бэрхшээл

Аймаг дахь Төрийн аудитын байгууллагын аудиторууд Ковид-19 вирусн халдвар авсан, мөн аудитын нэгдсэн төлөвлөгөөг төлөвлөсөн хугацаанд ирүүлээгүй зэргээс аудитыг богино хугацаанд гүйцэтгэж, аудиторууд ажлын ачаалалттай ажилласан.

Аудитад хамрагдагч этгээдээс аудитад шаардлагатай судалгааг авахаар ЭМГ-т хандаж, албан бичиг хүргүүлсэн боловч зарим хувийн эмийн сан болон эрүүл мэндийн байгууллагаас судалгааг бүрэн ирүүлээгүй.

Тус аудитаар шалгах зарим асуудалд эмзүйн салбарын мэргэжилтэн, шинжээч татан оролцуулах шаардлага гарсан.

Ерөнхий мэдээлэл:

Улсын Их Хурлын 2014 оны 57 дугаар тогтоолоор “Төрөөс эмийн талаар баримтлах бодлого”-ыг баталжээ. Уг баримт бичгийн зорилгыг “Хүн ам, эрүүл мэндийн байгууллагыг эмчилгээний өндөр идэвхтэй, аюулгүй, чанарын баталгаатай, сонголт хийх боломж бүхий эмээр тасралтгүй, жигд, хүртээмжтэй хангаж, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх” гэж тодорхойлсон байна. Уг бодлогын баримт бичгийн 1.2-т бодлогыг 2014-2018 онд хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Эмийн талаар орон нутагт баримтлах бодлого”-ыг боловсруулахаар тусгасан. Уг зорилт болон УИХ-аас баталсан дээрх бодлогын баримт бичгийг үндэслэн хэрэгжүүлэх журмыг аймгийн Засаг даргын 2016 оны А/573 дугаар тушаалаар баталсан байна.

Засгийн газрын 2017 оны 24 дүгээр тогтоолоор “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого”-ыг баталж, Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/443 дугаар тушаалаар бодлогыг 2018-2020 онд хэрэгжүүлэх төлөвлөгөө, 2020 оны А/103 дугаар тушаалаар 2020-2026 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг тус тус баталсан байна.

Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого болон аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг үндэслэн аймгийн ИТХТ-ын 2017 оны 53 дугаар тогтоолоор “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг Дорноговь аймагт хэрэгжүүлэх аймгийн дэд хөтөлбөр”-ийг баталсан байна. Уг дэд хөтөлбөрийн хүрээнд үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлэн ажиллаж байна.

Дорноговь аймагт 2018-2020 онуудад нийт 4 эм ханган нийлүүлэх байгууллага үйл ажиллагаа явуулсан бол 2018 онд 43, 2019 онд 45, 2020 онд 45 эмийн сан үйл ажиллагаа явуулсан байна. 2020 онд үйл ажиллагаа явуулсан 45 эмийн сангийн 28 нь хувийн, 17 эргэлтийн эмийн сан байна. 2020 оны байдлаар 1 дүгээр зэрэглэлийн 11 эмийн сан, 2 дугаар зэрэглэлийн 34 эмийн сан үйл ажиллагаа явуулсан байна.

2018-2020 онуудад шинээр 8 тусгай зөвшөөрөл олгож, 5 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгожээ. 2021 онд нийт 5 эмийн санд шинээр тусгай зөвшөөрөл олгожээ.

Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох хөнгөлөлттэй эмийг нийт 38 эмийн сан гэрээ байгуулан олгож байна. Эрүүл мэндийн даатгалын сангаас 2018 онд 771.8 сая, 2019 онд 746.3 сая, 2020 онд 756.8 сая төгрөгийг эмийн сангуудад олгосон байна.

Аймгийн эрүүл мэндийн байгууллагад 2020 онд нийт 41 эм зүйч, 71 эм найруулагч ажилласан байна.

АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь салбар сургуулийн эм найруулагчийн ангийг 2018 онд 7, 2019 онд 10, 2020 онд 7 оюутан төгссөн байна.

Аймгийн хэмжээнд сүүлийн 3 жилийн эм, эмнэлгийн хэрэгслийн борлуулалт, зарцуулалтын хэмжээ болон нэг иргэнд ногдох эмийн зардлын хэмжээг хүснэгт 1-д харуулав.

Хүснэгт 1: Эм, эмнэлгийн хэрэгслийн борлуулалт, зарцуулалтын хэмжээ

Он	Төрийн өмчит эрүүл мэндийн байгууллагын эм, эмнэлгийн хэрэгслийн зарцуулалт, сая төгрөг	Эмийн сангийн эм, эмнэлгийн хэрэгслийн борлуулалт, сая төгрөг	Нийт, сая төгрөг	Хүн амын тоо ¹	Жилд 1 хүнд ногдох эм, эмнэлгийн хэрэгслийн зардал, мянган төгрөг
А	1	2	3=1+2	4	5=3/4
2018	1,953.56	5,497.89	7,451.45	69,560	107.1
2019	2,396.67	7,035.94	9,432.61	69,826	135.1
2020	3,193.65	7,938.29	11,131.94	69,859	159.3

¹Эх сурвалж: Дорноговь аймгийн статистикийн эмхэтгэл, 2018, 2019, 2020 он

Нэг иргэнд ногдох эм, эмнэлгийн хэрэгслийн зардал 2018 оноос хойших 2 жилийн хугацаанд 48.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

А. ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙГАА НЬ ЭМИЙН ХАНГАЛТ, ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДАЛД СӨРГӨӨР НӨЛӨӨЛӨХ ЭРСДЭЛТЭЙ БАЙНА.

А.1. Төрөөс эм, эмнэлгийн хэрэгслээр хангах бодлогын хэрэгжилтийн үр дүнг сайжруулах шаардлагатай байна.

А.1.1.Нийтийн үйлчилгээтэй эмийн сангуудад зайлшгүй шаардлагатай эмийн хангалтын нөөц стандартад заасан хувь, хэмжээнээс бага байна.

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Эмийн сангийн ... үйлчлэх хүрээг тухайн орон нутгийн онцлогт тохируулан тогтоох, эм, эмнэлгийн хэрэгслээр хангах үйл ажиллагааг зохицуулах үүргийг нутгийн захиргааны байгууллага хүлээнэ” гэж заажээ.

Тус аймагт 2020 оны байдлаар тусгай зөвшөөрөлтэй нийт 104 эрүүл мэндийн байгууллага үйл ажиллагаа явуулж байна. /Хүснэгт 2-т харуулав/. 2021 онд нийт 5 эмийн санд шинээр тусгай зөвшөөрөл олгосон байна.

Хүснэгт 2: Эрүүл мэндийн байгууллагын тоо /2020 оны байдлаар/

Байгууллагын ангилал	Байгууллагын тоо
Эрүүл мэндийн байгууллага	
-нэгдсэн эмнэлэг	2
-сум дундын эмнэлэг	1
-уламжлалт, анагаах ухаан рашаан сувиллын төв	1
-сумын эрүүл мэндийн төв	12
-өрхийн эрүүл мэндийн төв	4
-ортой хувийн эмнэлэг	5
-сувилал	3
-лаборатори	1
-үүдэн эмнэлэг	20
-цэргийн ангийн эмнэлэг	2
-шавьж устгах, ариутгал, халдваргүйтгэл хийх байгууллага	4
Эм хангамжийн байгууллага	
-эм ханган нийлүүлэх байгууллага	4
-эмийн сан	45
НИЙТ	104

Аудитад дээрх байгууллагуудаас төрийн өмчит эрүүл мэндийн байгууллага болон эм хангамжийн нийт 69 байгууллагыг хамруулсан болно.

Ард иргэдийг эм, эмнэлгийн хэрэгслээр жигд, хүртээмжтэй хангах зорилгоор аймгийн ИТХ-ын 2009 оны 98 дугаар тогтоолоор Эм эргэлтийн сан ОНӨААТҮГ-ыг байгуулж, дээрх тогтоолыг үндэслэн аймгийн Засаг даргын 2010 оны А/10 захирамжаар тус газрын дүрэм, бүтэц орон тоог баталжээ.

Ингэснээр аймгийн төвийн төдийгүй алслагдсан сумдын иргэдийг хямд үнэтэй, чанарын баталгаатай, аюулгүй эмээр хангах нэгдсэн удирдлага, тогтолцоо бүрдсэн байна. ЭЭС нь 2010 оноос нийт 12 суманд эмийн сангийн үйл ажиллагаа эрхэлж байсан бол 2013, 2016 онд Айраг, Замын-Үүд сумдад эмийн санг шинээр байгуулснаар аймгийн бүх сумдын иргэдэд хүрч үйлчлэх нөхцөл бүрдсэн байна. 2021 оны байдлаар ЭЭС-ийн 17 эмийн сан, 1 эм ханган нийлүүлэх байгууллага үйл ажиллагаа явуулж байна.

ЭЭС нь иргэдэд эм, эмнэлгийн хэрэгслээр үйлчлэхийн зэрэгцээ сумдын ЭМТ-ийн эмийн хэрэгцээг ханган, хадгалалт, тээвэрлэлт зэрэг эмийн чанар, аюулгүй байдалтай холбоотой асуудлыг гэрээнд тусгасны дагуу бүрэн хариуцаж байжээ. Харин 2019 оноос сумдын ЭМТ-үүдийн эмийн ХАА-г аймгийн ЭМГ-т нэгтгэн зохион байгуулж, сумдын ЭМГ-ууд эм, эмнэлгийн хэрэгслийг тендерт шалгарсан эм ханган нийлүүлэх байгууллагуудаас худалдан авч, ЭМТ-ийн байранд хадгалан, зарцуулж байна.

Энэ нь сумдын ЭМТ-үүд эм, эмнэлгийн хэрэгслийг стандартад нийцсэн хадгалах өрөө тасалгаа, техник, тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдаагүй, эмзүйн мэргэжлийн хүний нөөц дутмаг байгаа нь эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөхөөс гадна иргэд болон эмч нарт эмийн зохистой хэрэглээг тайлбарлаж зөвлөгөө өгөх ажил орхигдоход хүргэж байна.

Эмийн сан болон хүн амын тоо, байршлын судалгааг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 3: Эмийн сангийн тоо, сумдаар /2020 оны байдлаар/

№	Сумын нэр	Эмийн сангийн тоо			Хүн, амын тоо ¹	Нэг эмийн санд ногдох хүн амын тоо
		I зэрэглэл	II зэрэглэл	Нийт		
А	Б	1	2	3	4	5=4/3
1	Айраг		2	2	3,638	1,819
2	Алтанширээ		1	1	1,318	1,318
3	Даланжаргалан		2	2	3,005	1,503
4	Дэлгэрэх		1	1	1,817	1,817
5	Замын-Үүд	2	6	8	18,804	2,351
6	Иххэт		1	1	2,083	2,083
7	Мандах		1	1	1,553	1,553
8	Өргөн		1	1	2,139	2,139
9	Сайхандулаан		1	1	1,368	1,368
10	Сайншанд	9	13	22	25,910	1,178
11	Улаанбадрах		1	1	1,476	1,476
12	Хатанбулаг		2	2	2,850	1,425
13	Хөвсгөл		1	1	1,561	1,561
14	Эрдэнэ		1	1	2,337	2,337
	НИЙТ	11	34	45	69,859	
	Дундаж					1,552

¹Эх сурвалж: Дорноговь аймгийн статистикийн эмхэтгэл, 2020 он

Нийтийн үйлчилгээтэй эмийн санд 2018, 2019, 2020 онуудад тус тус нэг, 2021 онд 5 эмийн санд тусгай зөвшөөрлийг шинээр олгож, тус онуудад Сайншанд суманд үйл ажиллагаа явуулж байсан 2 эмийн сан, Замын-Үүд суманд үйл ажиллагаа явуулж байсан 1 эмийн сангийн тусгай зөвшөөрлийг цуцалсан байна.

“MNS 5260:2015 Эмийн санд тавих нийтлэг шаардлага”-ын 11.10-т “Нийтийн үйлчилгээтэй эмийн сан нь зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад орсон, эмийн сангаар худалдахыг зөвшөөрсөн эмийн 90-ээс доошгүй хувийн хангах нөөцтэй байна” гэж заасан.

ЭМС-ын 2017 оны А/350 дугаар тушаалаар “Зайлшгүй шаардлагатай эмийн 8 дахь жагсаалт”-ыг баталсан. /ЭМС-ын 2020 оны 12 дугаар сарын 25-ны А/625 дугаар тушаалаар ЗШЭ-ийн 9 дэх жагсаалтыг баталсан боловч аудитын хамрах хугацаа болох 2018-2020 онд мөрдөгдөж байсан ЗШЭ-ийн 8 дахь жагсаалтыг аудитад шалгуураар ашиглав/.

ЗШЭ-ийн жагсаалтад нийт 422 эм тусгагдсан ба аймгийн Эрүүл мэндийн газраас 265 эмийн хангалтын нөөцөд 2020 онд хяналт, шалгалтыг хийсэн байна. Уг тоо баримтад үндэслэн ЗШЭ-ийн 8 дахь жагсаалтад тусгагдсан эмийн хангалтын нөөцийг тодорхойлов /Хавсралт 1/. Үүнд,

- 90-ээс дээш хувийн хангалтын нөөцийг бүрдүүлсэн 1 эмийн бүлэг,
- 70-89 хувийн хангалтын нөөцийг бүрдүүлсэн 4 эмийн бүлэг,
- 60-69 хувийн хангалтын нөөцийг бүрдүүлсэн 5 эмийн бүлэг,
- 50-59 хувийн хангалтын нөөцийг бүрдүүлсэн 2 эмийн бүлэг,
- 40-49 хувийн хангалтын нөөцийг бүрдүүлсэн 4 эмийн бүлэг,
- 30-39 хувийн хангалтын нөөцийг бүрдүүлсэн 4 эмийн бүлэг,
- 30-аас доош хувийн хангалтын нөөцийг бүрдүүлсэн 5 эмийн бүлэг.

Халдваргүйжүүлэх ба үжлийн эсрэг бодис бүлэгт тусгагдсан эм нь стандартад заасан шаардлага буюу 90-ээс дээш хувийн хангах нөөцтэй байгаа бол хавдрын эсрэг, дархлал дарангуйлах, хөнгөвчлөх эмчилгээний эмийн бүлэг, мигрень эмчлэх эмийн бүлгийн эмийн хангалт хамгийн бага буюу 0-1.5 хувьтай байна.

Мэргэжлийн хяналт, ЭМГ-аас 2018-2020 онуудад Сайншанд болон Замын-Үүд сумдад үйл ажиллагаа явуулдаг нийт 33 эмийн сангийн үйл ажиллагаанд шалгалт хийхэд ЗШЭ-ийн хангалтын нөөц дунджаар 69.8 хувь байна. Хяналт, шалгалтад хамрагдаагүй эмийн сангуудын нөөцийн хувийг тодорхойлох зорилгоор ЭЭС-ийн 13 эмийн сангийн тайлан, мэдээг нэгтгэж үзэхэд, хангалт дунджаар 73.4 хувьтай байна.

ЗШЭ-ийн хангалтын нөөцийн хувь стандартад тусгагдсан хэмжээ буюу 90 хувийг хангахгүй байгаа шалтгааны талаар объект дээр очиж ажилласан эмийн сангуудын ажилтнаас тодруулахад эмч нар тус жагсаалтад тусгагдсан эмийг өвчтөнд хэрэглэхийг зөвлөөгүй, тус жагсаалтад тусгагдсан эмийн нөөцийг бүрдүүлэх зорилгоор татан авсан эмийг худалдан авахгүйгээс эмийн хугацаа дуусаж, эмийг устгах шаардлага гардаг, зарим эм нь өндөр өртөгтэй тул үйлчлүүлэгч тогтмол худалдан авдаггүй, эмийн сангийн төсөв дутагдах зэрэг хүндрэл үүсдэг талаар тайлбарлаж байв.

Мөн ЭМГ-ын холбогдох мэргэжилтнээс дээрх асуудлаар тодруулахад ЗШЭ-ийн жагсаалт дахь эмийн нэр давхардсан, МУ-ын эмийн бүртгэлд бүртгэгдээгүй, бүртгэлээс хасагдсан зэрэг шалтгаанаар эмийн нөөц стандартад заагдсан хэмжээнд хүрэхгүй байх тохиолдол гардаг талаар тайлбарлаж байв.

Эмийн хангалт болон нөөц бүрдүүлэлтийг шалгах зорилгоор 14 байгууллагын 2018-2020 онуудад хөтөлсөн тасарсан эмийн бүртгэлийг аудитын явцад авч үзэв.

“MNS 5260:2015 Эмийн санд тавих нийтлэг шаардлага”-ын 20.2.1-д “Нийтийн үйлчилгээтэй эмийн санд ...тасарсан эмийн бүртгэлийг тогтмол хөтөлж... 2-оос доошгүй жил хадгална”, ЭМС-ын 2019 оны А/414 дүгээр тушаалаар батлагдсан “Эмийн эмчилгээний зохицуулах хорооны ажиллах журам”-ын 3.1.5-д “Хороо нь эмийн эмчилгээний тасалдлыг хянах...” гэж заасан.

Аудитын явцад 14 байгууллагад очиж шалгахад тасарсан эмийн бүртгэлийг хөтөлдөг гэх боловч 7 байгууллагад байхгүй ба тасарсан эмийн бүртгэлийг архивлаагүй байна. Тасарсан эмийн бүртгэл хөтлөлт хангалтгүй байгаа нь эмийн сан болон эрүүл мэндийн байгууллагын эмийн сангийн ажилтан солигдсон, мөн ажилтны хариуцлагагүй байдал зэрэгтэй холбоотой байна.

УИХ-ын 2014 оны 57 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс эмийн талаар баримтлах бодлого”-ын 3 дугаар зүйлд тусгасан зорилтын 7.2.1.1-д “зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, вакцин болон өнчин эм худалдан авах ажиллагааг нэгтгэн зохион байгуулах...”, аймгийн Засаг даргын 2016 оны А/573 дугаар захирамжаар батлагдсан “Төрөөс эмийн талаар баримтлах бодлого”-ыг орон нутагт хэрэгжүүлэх нийтлэг журмын 2.4-т “Эрүүл мэндийн газар нь МУ-ын ТБОНӨХБАҮХАТХ-ийн хүрээнд төрийн болон орон нутгийн өмчийн эрүүл мэндийн байгууллагуудын хэрэгцээт МУ-ын эмийн бүртгэлд бүртгэгдсэн, эмчилгээний өндөр идэвхтэй, аюулгүй, чанарын баталгаатай эм, эмнэлгийн хэрэгслийг худалдан авах үйл ажиллагааг төвлөрүүлэн зохион байгуулж, тасралтгүй хангах нөхцөлийг бүрдүүлж, гүйцэтгэлд хяналт тавина” гэж заасан.

Дээрх заалтын дагуу аймгийн ЭМГ нь тус аймагт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчит эрүүл мэндийн байгууллагуудын худалдан авах ажиллагааг нэгтгэн зохион байгуулсан байна.

Хүснэгт 4: Эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авах ажиллагааны мэдээлэл

Он	Нэгдсэн эмнэлэг, ЭЭС			ЭМТ		
	Захиалагч байгууллагын тоо	Багцын тоо	Үнийн дүн, сая төгрөг	Захиалагч байгууллагын тоо	Багцын тоо	Үнийн дүн, сая төгрөг
А	1	2	3	4	5	6
2018	3	33	2,383.9	-	-	-
2019	2	36	1,336.8	13	20	143.9
2020	2	55	1,516.2	13	36	150.8

ЭЭС-ийн эмийн ХАА-г 2019 оноос өмнөх жилүүдэд ЭМГ-т нэгтгэн зохион байгуулж байсан бол 2019 оноос ХАА-г тухайн байгууллага зохион байгуулжээ.

А.1.2. Төрөөс эмийн үндэсний үйлдвэрлэлийг тус аймагт байгуулах зорилтыг бодлогын баримт бичиг болон хамтран ажиллах гэрээнд тусгаагүй учир орон нутгийн бодлогод энэ чиглэлийн арга хэмжээг төлөвлөөгүй байна.

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Хүний эм, эмнэлгийн хэрэгсэл болон мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эм, тэдгээрийн угтвар бодис, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх... тусгай зөвшөөрлийг эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага олгоно”, УИХ-ын 2014 оны 57 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс эмийн талаар баримтлах бодлого”-ын 7.3-т төрөөс эмийн үйлдвэрлэлийг дэмжих 4 чиглэлийг заасан байна. Мөн ЗГ-ын 2017 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого”-ын 2.4.6.9-д “Үндэсний эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэлийг олон улсын түвшинд хүргэж, ургамал, амьтан, эрдсийн гаралтай уламжлалт эм, импортыг орлох зайлшгүй шаардлагатай эмийн үйлдвэрлэл, экспортыг дэмжих” гэж тус тус заажээ.

Дорноговь аймгийн Засаг дарга, Эрүүл мэндийн сайдтай хамтран ажиллах 2018-2020 онуудын гэрээ, мөн төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг аймагт хэрэгжүүлэх дэд хөтөлбөр, төлөвлөгөөнд тус аймагт эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрийг байгуулах чиглэлээр эрх, үүрэг, зорилт, арга хэмжээ тусгагдаагүй байна.


А.1.3. Эм, эмнэлгийн хэрэгслийн удирдлагын мэдээллийн системийг бүрдүүлэх ажил эхэлсэн боловч системийн хөгжүүлэлт бүрэн хийгдээгүйгээс ашиглалт хангалтгүй байна.

УИХ-ын 2014 оны 57 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс эмийн талаар баримтлах бодлого”-ын 11 дүгээр зүйлийн 11.2.2-т “эм зүйн салбарын ...мэдээллийн сан бүрдүүлж, хэрэглээг тогтмолжуулна”, ЭМС-ын 2018 оны А/443 дугаар тушаалаар батлагдсан “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг 2018-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай” төлөвлөгөөний 6.6.1-т “Үндэсний аюулгүй байдлын мэдээллийн цахим санг үндэсний хэмжээнд байгуулж эхлэх” гэж заажээ.

Эм, эмнэлгийн хэрэгслийн цахим санг бүрдүүлэх чиглэлээр Эрүүл мэндийн яамнаас Licemed.mohs.mn системийг нэвтрүүлсэн байна. Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/295 дугаар тушаалаар батлагдсан “Эм, эмнэлгийн түүхий эд, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг бүртгэх журам”-д зааснаар Licemed системд эмийн түүхий эд, оношлуур, БИБ-ний бүртгэлийн үйл ажиллагаа нь суурилна гэж тусгасан ба бүртгэлийн үйл ажиллагааны явцад тус программд мэдээллийг оруулахаар заасан байна.

Уг системийн ашиглалтын талаар шалгагдагч эмийн сан болон эрүүл мэндийн байгууллагуудын ажилтнаас тодруулахад системийг мэддэг боловч ашигладаггүй гэж тайлбарлаж байлаа.

Зураг 1: Licemed.mohs.mn систем



ЭМС-ын баталсан дээрх төлөвлөгөөний 6.6.2-т “Цахим жорыг нэвтрүүлэх...” гэж заасан байна.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын health.gov.mn системийг тус аймагт үйл ажиллагаа явуулж байгаа бүх эрүүл мэндийн байгууллага ашиглаж байгаа ба системд эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөгдөх эмийн жор бичих, дархлаажуулалтыг бүртгэх зэрэгт ашиглаж байна.

ЭМС-аас баталсан төлөвлөгөөнд жорыг цахимжуулахаар тусгасан боловч зөвхөн ЭМД-ийн сангаас хөнгөлөлт үзүүлдэг эмийн жорыг цахимаар бүртгэж, хөнгөлөлтөд хамрагдаагүй эмийн жорыг цахимаар бүртгэх боломжгүй байна.

ЭМС-ын 2017 оны А/19 дүгээр тушаалаар батлагдсан “Эм, эмнэлгийн хэрэгслийн аюулгүй байдлын программыг нэвтрүүлэх журам”-ын 2.5-д “...программ

нь дараах дэд хэсгүүдтэй байна. Үүнд: Эм, эмнэлгийн хэрэгслийн бүртгэл, мэдээллийн модуль, борлуулалт түгээлтийн модуль, цахим жорын модуль, эмийн гаж нөлөөний бүртгэл, мэдээллийн модуль” гэж заасан.

Дээрх журамд заасан 4 модуль бүхий программ нэвтрээгүй байна.

Тус аймгийн төрийн өмчит эрүүл мэндийн байгууллага болон эмийн сан, эм хангамжийн байгууллагуудад эмийн бүртгэлийн программ хангамжийн судалгааг авч үзэхэд байгууллагууд эмийн орлого, зарлагын бүртгэл болон эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлт үзүүлдэг эмийн цахим жороор эм олгох үйлдлийг программ хангамжаар гүйцэтгэдэг байна.

Аймгийн Нэгдсэн эмнэлэг болон Замын-Үүд сумын нэгдсэн эмнэлэгт eHealth программыг ашиглаж эхлэх бэлтгэл хангагдсан боловч программын хөгжүүлэлт хийгдээгүй шалтгаанаар уг программыг ашиглаагүй байна. Тус программд эм, эмнэлгийн хэрэгслийн орлого, зарлага зэргийг цахимаар гүйцэтгэх боломжтой хэдий ч одоогоор зөвхөн эмийн үлдэгдлийг программд шивж оруулсан ба орлого, зарцуулалтыг гүйцэтгэх боломжгүй байна.

Судалгаанд хамрагдсан байгууллагад ашиглагдаж байгаа программ хангамжийг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 5. Эм, эмнэлгийн хэрэгсэл бүртгэх программ хангамж

Байгууллагын төрөл	Орион Фарм	ERP	MACS	Даймонд 5.0	Санхүүгийн программ
А	1	2	3	4	5
Эмийн сан	34	3	1	3	
Эм ханган нийлүүлэх байгууллага	2	1	1	1	
ЭМТ					16
Нэгдсэн болон сум дундын эмнэлэг					3

Монгол Улсад бүртгэлтэй эм, эмийн гаж нөлөө болон эмийн орлого, зарцуулалтын бүртгэл зэргийг тусгасан мэдээллийн систем манай улсад нэвтрээгүй байна.

Иймээс эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдал, худалдан авалт, борлуулалт зэрэг мэдээллийг хянах боломж бүрдээгүй байна.

A.2. Улсын төсвөөс олгох эмийн санхүүжилтийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

A.2.1. Эрүүл мэндийн даатгалын сан болон улсын төсвөөс санхүүжилтийг бүрэн олгосон боловч эмийн зардлын төсвийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

УИХ-ын 2014 оны 57 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс эмийн талаар баримтлах бодлого”-ын 7 дугаар зүйлийн 7.4.1-д “Зонхилон тохиолдох өвчин эмгэгийн эмчилгээ, оношилгоонд шаардагдах эм, эмнэлгийн хэрэгслийн зардлыг улсын төсөв болон эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлнэ”, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3-т “Даатгуулагч Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.1, 15.1.2, 15.1.4, 15.1.5, 15.1.7, 15.1.9, 15.1.11, 15.1.13-т заасан эрүүл мэндийн байгууллагын эмчийн бичсэн жороор эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад орсон ерөнхий

нэршлийн эмийг тухайн эрүүл мэндийн байгууллагын эмийн сан, бусад эмийн сангаас худалдан авах тохиолдолд үнийн хөнгөлөлт үзүүлнэ” гэж тус тус заасан байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас зонхилон тохиолдох өвчин эмгэгийн эмчилгээ, оношилгоонд шаардагдах эм, эмнэлгийн хэрэгслийн зардалд жил бүр дэмжлэг үзүүлсэн ба дэмжлэгийг ЭМДҮЗ-ийн тогтоолоор баталсан “Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх зайлшгүй шаардлагатай эмийн нэр, төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээ”-ний жагсаалтад үндэслэн олгодог байна. Тус жагсаалтад 2018 оноос элэгний С вирусийн эсрэг эмийг, 2019 оноос элэгний В вирусийн эсрэг эмийг нэмж тусгасан байна.

ЭМДС-аас тус аймгийн хэмжээнд зонхилон тохиолдох өвчин, эмгэгийн эмчилгээ, оношилгоонд шаардагдах эм, эмнэлгийн хэрэгслийн зардалд 2018 онд 771.8 сая төгрөг, 2019 онд 746.3 сая төгрөг, 2020 онд 709.7 сая төгрөгийн санхүүжилтийг ЭМД-ын сангаас тус тус олгосон байна. Дараах хүснэгтэд ЭМДС-аас олгох санхүүжилтийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг харуулав.

Хүснэгт 6: ЭМДС-аас олгох хөнгөлөлттэй эмийн зардлын санхүүжилт, сая төгрөг

Он	Төлөвлөгөө	Гүйцэтгэлээр олгохоор тооцсон	Олгосон	Зөрүү
А	1	2	3	4=2-3
2018	650.7	771.8	771.8	-
2019	669.5	746.3	746.3	-
2020	704.9	756.8	756.8	-
Дүн	2,025.1	2,274.9	2,274.9	-

Зонхилон тохиолдох өвчин, эмгэгийн зонхилон тохиолдох өвчин, эмгэгийн эмчилгээ, оношилгоонд шаардагдах эм, эмнэлгийн хэрэгслийн зардалд улсын төсвөөс үзүүлсэн дэмжлэгийг төрийн өмчит эрүүл мэндийн байгууллагын эм, эмнэлгийн хэрэгслийн зардлын төсөв, гүйцэтгэлд үндэслэн тодорхойлов.

Төрийн өмчит 6 эрүүл мэндийн байгууллага, тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг 16 өрхийн болон сумын эрүүл мэндийн төвүүдэд 2018 онд 1,996.3 сая төгрөг, 2019 онд 2,181.7 сая төгрөг, 2020 онд 2,942.2 сая төгрөгийг тус тус улсын төсвөөс эмийн зардалд олгосон байна.

Хүснэгт 7: Төрийн өмчит 6 эрүүл мэндийн байгууллагын эмийн зардлын санхүүжилт, сая төгрөг

№	Байгууллагын нэр	2018 он			2019 он			2020 он		
		Төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
А	Б	1	2	3=1-2	4	5	6=4-5	7	8	9=7-8
1	Эрүүл мэндийн газар	2.1	2.7	(0.5)	2.5	2.5	-	114.4	114.4	-
2	Аймгийн Нэгдсэн эмнэлэг	1,413.7	1,413.7	-	1,286.9	1,292.4	(5.5)	2,196.6	1,892.3	304.31
3	Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлэг	334.2	332.9	1.3	427.6	427.6	0.0	473.8	473.8	0.00
4	Зүүнбаян дахь сум дундын эмнэлэг	23.9	28.7	(4.8)	39.9	42.4	(2.5)	30.5	33.0	(2.49)
5	Уламжлалт анагаах ухаан, рашаан сувилалтын төв	25.8	26.0	(0.2)	32.0	31.6	0.4	43.9	43.4	0.56
6	Халзан-Уул рашаан сувилал	2.0	1.3	0.7	2.0	1.9	0.0	5.2	4.6	0.65
	НИЙТ	1,801.8	1,805.3	(3.5)	1,790.9	1,798.5	(7.6)	2,864.4	2,561.4	303.02

Дээрх хүснэгтээс харахад 2020 онд эмийн зардалд олгосон санхүүжилт өмнөх оноос 763.0 сая төгрөгөөр буюу 42 хувиар өссөн нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- Ковид-19 цар тахлын тархалт нэмэгдсэнтэй холбоотойгоор ЭМЯ-аас аймгийн ЭМГ-т оношлуур худалдан авахад зориулан 113.4 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон.
- Аймгийн Нэгдсэн эмнэлгийн эмийн санхүүжилт 2020 онд өмнөх оноос 599.9 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байгаа нь шаардлагатай лабораторийн урвалж, оношлуур, хүчилтөрөгчийн тоо нэмэгдсэн, эм, эмнэлгийн хэрэгслийн үнэ өссөнтэй холбоотой байна.
- УАУРСТ болон Халзан-Уул рашаан сувиллын санхүүжилт 2020 онд өмнөх оноос 14.5 сая төгрөгөөр өссөн нь эмнэлгийн орны тоо нэмэгдсэн, уламжлалт эмчилгээг европ эмтэй хавсарсан эмчилгээг үзүүлж эхэлсэн, эмийн үнийн өсөлт, халдваргүйтгэл, ариутгалын бодис эмнэлгийн нэг удаагийн хэрэгслийн худалдан авалт өссөн зэрэг шалтгаантай байна.

Хүснэгт 8: Сумдын болон өрхийн эрүүл мэндийн төвийн эмийн зардлын санхүүжилт, (сая төгрөг)

№	Байгууллагын нэр	2018		2019		2020	
		Төл-гөө	Гүйц-л	Төл-гөө	Гүйц-л	Төл-гөө	Гүйц-л
А	Б	1	2	3	4	5	6
1	Айраг сумын ЭМТ	19.8	19.8	33.2	33.2	31.4	31.4
2	Алтанширээ сумын ЭМТ	18.1	18.2	22.7	22.6	22.4	22.4
3	Даланжаргалан сумын ЭМТ	16.4	16.2	33.7	33.7	30.5	30.5
4	Дэлгэрэх сумын ЭМТ	15.0	15.0	24.5	24.5	21.0	21.0
5	Иххэт сумын ЭМТ	16.9	16.9	28.2	27.9	29.0	29.0
6	Мандах сумын ЭМТ	13.2	13.1	21.1	21.0	21.4	21.4
7	Өргөн сумын ЭМТ	11.4	11.2	23.6	23.9	18.7	18.7
8	Сайхандулаан сумын ЭМТ	11.0	11.0	19.7	19.7	19.6	19.3
9	Улаанбадрах сумын ЭМТ	15.3	15.3	19.8	19.7	19.4	19.4
10	Хатанбулаг сумын ЭМТ	16.6	16.6	34.3	32.5	31.0	31.0
11	Хөвсгөл сумын ЭМТ	13.7	13.6	27.2	27.2	20.5	20.4
12	Эрдэнэ сумын ЭМТ	15.3	15.3	30.9	28.3	29.4	29.4
13	Агатова ӨЭМТ	0.6	1.9	6.9	14.6	5.9	17.2
14	Мишээлт мана ӨЭМТ	1.2	1.2	12.9	18.6	7.2	21.0
15	Талст зам ӨЭМТ	-	2.9	4.8	10.2	4.6	8.2
16	Борхойн наран ӨЭМТ	2.7	2.7	25.3	25.7	41.4	40.4
	Нийт	187.2	191.0	368.8	383.2	353.4	380.8

Сумдын болон өрхийн эрүүл мэндийн төвийн эм, эмнэлгийн хэрэгслийн зардалд олгосон санхүүжилт 2019, 2020 онд өмнөх оноос дунджаар 191.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2018 оны 08 дугаар тогтоолоор “Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх зарим тусламж үйлчилгээнд эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг хариуцах журам” батлагдсанаар эрүүл мэндийн даатгалын сангаас 4 тусламж, үйлчилгээний багцыг санхүүжүүлсэнтэй холбоотой байна.

Улсын төсвөөс эм, эмнэлгийн хэрэгслийн зардалд олгосон санхүүжилт хүрэлцэхгүй байгаатай холбоотойгоор аймгийн Нэгдсэн эмнэлэг 2019 онд 281.6 сая

төгрөгийн, 2020 онд 82.0 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийн өглөгтэй ажилласан байна.

ЭМДС-аас эм, эмнэлгийн хэрэгслийн зардалд олгох санхүүжилтийг 2018-2020 онуудад бүрэн олгожээ. Харин улсын төсвөөс тус зардалд хуваарилсан санхүүжилт хүрэлцэхгүй байна.

А.2.2. Санхүүгийн дарамт үүсгэх, өндөр өртөгтэй эмнэлгийн хэрэгсэлд төсвөөс санхүүжилт олгогдоогүй байна.

УИХ-ын 2014 оны 57 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс эмийн талаар баримтлах бодлого”-ын 7 дугаар зүйлийн 7.4.2-т “*Санхүүгийн дарамт үүсгэх өвчин эмгэгийн эмчилгээ, оношилгоонд шаардагдах өндөр өртөгтэй эм, эмнэлгийн хэрэгслийн зардлыг улсын төсөв болон эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлнэ*” гэж заасан байна.

Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2018 оны 11 дүгээр тогтоол, 2020 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан “Өндөр өртөгтэй зарим тусламж, үйлчилгээ, шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл, зарим төрлийн хиймэл цорго, сэргээн засах зориулалтаар хийгдэх протез, ортопедийн хэрэгслийн зардлын төлбөрийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх, хяналт тавих журам”-д өндөр өртөгтэй эмнэлгийн хэрэгслийн жагсаалтыг баталсан байна.

Дорноговь аймагт 2018-2020 онуудад улсын төсвөөс болон ЭМДС-аас дээрх жагсаалтад тусгагдсан эмнэлгийн хэрэгслийн зардалд санхүүжилт олгогдоогүй байна.

А.2.3 Ядуу, эмзэг бүлгийн хүн амд шаардлагатай эмийн зардлыг санхүүжүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлээгүй байна.

УИХ-ын 2014 оны 57 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс эмийн талаар баримтлах бодлого”-ын 7 дугаар зүйлийн 7.4.3-т “*Ядуу, эмзэг бүлгийн хүн амд шаардлагатай эмийн зардлыг санхүүжүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлнэ*” гэж заасан байна.

Ядуу, эмзэг бүлгийн хүн амд эмийн зардлыг авах хүсэлт эрүүл мэндийн байгууллагад бүртгэгдээгүй ба улсын болон орон нутгийн төсвөөс эмийн зардалд санхүүжилт олгоогүй байна.

А.3. Эмзүйн салбарын хүний нөөцийг бэлтгэх бодлого бүрэн хэрэгжихгүй байдлаас хүний нөөцийн дутагдал үүсч, эмийн хяналтын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлсөн байна.

А.3.1. Эм зүйн болон эрүүл мэндийн салбарын төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагууд хамтран ажиллах гэрээ, санамж бичгийг жил бүр байгуулдаг ч гэрээ, санамж бичигт тусгагдсан эмийн чиглэлээрх арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэх ажил хангалтгүй байна.

УИХ-ын 2014 оны 57 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс эмийн талаар баримтлах бодлого”-ын 9 дүгээр зүйлийн 9.1-д эмийн зохицуулалтын талаар тусгасан ба 9.1.4-т “*Эмийн зохицуулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн үүрэг хариуцлагыг тодорхой болгож, ажлын уялдааг сайжруулах*”, АИТХТ-ын 2017 оны 53 дугаар тогтоолоор

батлагдсан “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг Дорноговь аймагт хэрэгжүүлэх дэд хөтөлбөр”-ийг 2017-2021 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг аймгийн Засаг дарга баталсан ба уг төлөвлөгөөний 5.6.1-д АЗДТГ, МХГ, ЭМГ, “Эм” холбоо, ЭМДХ-ийн хамтран ажиллах чиглэл, арга хэмжээг тусгасан байна.

Эмийн зохицуулалт, хангалт, түгээлтийн үйл ажиллагаа эрхэлдэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагуудын үйл ажиллагааны харилцан уялдааг хууль эрхзүйн актад тусгагдсан эрх, үүрэг, хамтын ажиллагааны гэрээ, санамж бичигт үндэслэн тодорхойлов.

Эрүүл мэндийн сайд болон аймгийн Засаг даргын хамтран ажиллах гэрээг жил бүр байгуулдаг байна. Энэхүү хамтран ажиллах гэрээнд тусгагдсан зорилтыг аймгийн Эрүүл мэндийн газрын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний арга хэмжээг тодорхойлоход харгалзан үзэж, гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан, аймгийн Засаг даргаар батлуулдаг байна.

Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга, сумын Засаг дарга болон сумын Эрүүл мэндийн төвийн даргатай 2018, 2019 онуудад гуравласан гэрээ байгуулсан. Харин 2020 онд эрүүл мэндийн төвийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг аймгийн Эрүүл мэндийн газрын дарга болон тухайн сумын Засаг дарга нар баталсан байна.

Аймгийн Нэгдсэн эмнэлэг, Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлэг, Зүүнбаян дахь сум дундын эмнэлгийн дарга, Уламжлалт, анагаах ухаан, рашаан сувиллын төв болон Халзан-Уул рашаан сувиллын даргатай Эрүүл мэндийн газрын дарга жил бүр үр дүнгийн гэрээ байгуулж ажилласан байна. /2020 онд эмнэлгийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталсан байна/.

Монголын эмзүйн байгууллагуудын нэгдсэн “Эм” холбооны Дорноговь аймаг дахь салбар зөвлөлийн тэргүүнтэй Эрүүл мэндийн газрын дарга 2018-2020 онд жил бүр санамж бичиг байгуулсан байна.

Үүнээс гадна, 2019 онд “Эм эргэлтийн сан” ОНӨААТҮГ-ын даргатай, 2019, 2020 онуудад Төгс омбол эмийн сангийн захиралтай санамж бичиг байгуулжээ. Хувийн хэвшлийн бусад эмийн сангийн эрхлэгч болон байгууллагын захиралтай гэрээ байгуулаагүй ба төрийн бус байгууллагатай хамтран эмийн сангийн үйл ажиллагаанд аргазүйн зөвлөмж өгөх, хамтран ажиллахаар санамж бичигт тусгасан байна.

Эрүүл мэндийн ерөнхий газар нь 2020 онд нийт 38 эмийн сангийн эрхлэгчтэй, 2021 онд шинээр байгуулагдсан 3 эмийн сангийн эрхлэгчтэй гэрээ байгуулан ажилласан байна.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газар 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, аймгийн Засаг даргаар батлуулж ажилласан байна.

Дээрх байгуулсан гэрээ болон санамж бичигт эмийн хүртээмжийг нэмэгдүүлэх, хангамжийг сайжруулах, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, төрөөс эмийн болон эрүүл мэндийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангаж ажиллах чиглэл тусгагдсан байна.

Эрүүл мэндийн газрын дарга болон сумдын эрүүл мэндийн төв, сумдын Засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилтийг тусгайлсан шалгуур үзүүлэлтээр үнэлж

дүгнэдэг боловч эмийн чанар, аюулгүй байдал, хангамжийн чиглэлийн шалгуур үзүүлэлтийг тусгаагүй байна.

Эрүүл мэндийн газрын дарга болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд, төрийн бус байгууллагын удирдлагатай санамж бичгийг байгуулж байгаа нь тус баримт бичигт тусгагдсан талуудын эрх, үүргийн хэрэгжилтийг үнэлэх боломжгүйд хүргэж байна. Тухайлбал, “Эм” холбооны Дорноговь аймаг дахь салбар зөвлөлийн тэргүүнтэй байгуулсан санамж бичигт тусгасан арга хэмжээг зохион байгуулсан эсэх нь тодорхойгүй, үнэлсэн баримт материал байхгүй байна.

Аймгийн Эрүүл мэндийн газар нь эрүүл мэндийн салбарын төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагатай байгуулсан хамтран ажиллах гэрээг үнэлэх шалгуур үзүүлэлтэд эмийн чанар, аюулгүй байдал, хангалт, зохистой хэрэглээг тодорхойлсон үзүүлэлтийг тусгаж, санамж бичигт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэх шаардлагатай байна.

А.3.2. Мэргэжлийн хүний нөөц дутмаг байгаагаас зохицуулалтын болон хяналтын чиг үүрэг бүхий байгууллагаас эм, эмнэлгийн хэрэгсэлд тавих хяналт бүрэн хийгдээгүй байна.

УИХ-ын 2014 оны 57 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс эмийн талаар баримтлах бодлого”-ын 9 дүгээр зүйлийн 9.1.3-т “Төрөөс эмийн зохицуулалтын чиг үүрэг бүхий байгууллагын тогтвортой үйл ажиллагаа, санхүүгийн болон мэргэшсэн хүний нөөцийг бэхжүүлэх... талаар дэмжлэг үзүүлэх” гэж заасан байна.

Тус аймагт эмийн зохицуулалтын чиг үүргийг Засаг даргын тамгын газар, Мэргэжлийн хяналтын газар, Эрүүл мэндийн газар хэрэгжүүлж байна. Төрөөс эдгээр байгууллагад эмийн зохицуулалтын хүрээнд төрөөс санхүүгийн дэмжлэгийг үзүүлээгүй, мэргэшсэн хүний нөөцөөр хангах ажлын хүрээнд эмийн мэргэжилтний орон тоог баталж өгсөн байна.

Тиймээс тус асуудлын хүрээнд эм, эмнэлгийн хэрэгсэл хариуцсан албан тушаалтны тогтвор суурьшилтай болон мэргэжлийн хүний нөөцөөр хангагдсан байдлыг авч үзэв.

Аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн эрүүл мэндийн бодлого хариуцсан ахлах мэргэжилтэн эмийн талаарх бодлогын боловсруулалт, хэрэгжилтийг хариуцахаар албан тушаалын тодорхойлолтод заасан байна. Уг мэргэжилтэн нь 2016 оноос тус албан тушаалд томилогдон ажилласан ба албан тушаалын тодорхойлолтод заасан мэргэжлийн шалгуурыг хангасан байна.

Дорноговь аймгийн Эрүүл мэндийн газрын эмийн зохистой хэрэглээ, чанар, аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн эмийн талаар мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх чиг үүргийг хүлээсэн байна. Тус албан тушаал нь 2018 оны 10 дугаар сараас 2019 оны 10 дугаар сар хүртэлх 1 жилийн хугацаанд сул байсан ба 2019 оны 10 дугаар сараас эм зүйч мэргэжлээр төгссөн, албан тушаалын тодорхойлолтод заагдсан мэргэжлийн шалгуурыг хангасан хүний нөөцөөр хангагдсан байна.

Мэргэжлийн хяналтын газрын эм, биобэлдмэлийн хяналтын улсын байцаагч нь эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдалд хяналт шалгалтыг явуулдаг байна. Тус албан тушаал нь 2019 болон 2020 онуудад сул байсан ба 2020 оны 11 дүгээр сараас эм зүйч мэргэжлийн хүний нөөцөөр хангагдсан байна.

Тус аймагт эм зүйн салбарын хүний нөөцийн дутагдалтай байдлаас шалтгаалан хяналт болон зохицуулалтын байгууллагад ажиллах, сул орон тоог нөхөх мэргэжилтэн дутмаг байна. Сул орон тоог нөхөх талаар дээрх байгууллагууд ТАЗ болон бусад дээд шатны холбогдох байгууллагад удаа дараа албан бичиг хүргүүлж байжээ.

Хяналтын болон зохицуулалтын чиг үүрэг бүхий байгууллагын эм, эмнэлгийн хэрэгсэл хариуцсан мэргэжилтэн дутагдалтай байснаас шалтгаалан МХГ-аас 2019, 2020 онуудад, Эрүүл мэндийн газраас 2019 оны эхний хагас жилд эмийн чиглэлээр хяналт, шалгалт хийгдээгүй байна.

А.3.3. Мэргэжлийн хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах бодлогын хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

Аймгийн хэмжээнд эм хангамжийн болон эрүүл мэндийн байгууллагад стандартад заасны дагуу эмзүйн мэргэжлийн 164 мэргэжилтэн ажиллах ёстой боловч 2020 оны байдлаар 98 албан хаагч ажиллаж, 66 мэргэжилтэн дутагдалтай байна.

АШУҮИС-ийн Дорноговь салбар сургууль нь Дорноговь, Дундговь, Өмнөговь, Дорнод, Сүхбаатар, Хэнтий, Говьсүмбэр аймгаас эм зүйч болон эм найруулагч мэргэжлээр оюутнуудыг элсүүлэхээр АШУҮИС-ийн удирдлагын зөвлөлийн тогтоолд тусгаж, жил бүр элсүүлэх оюутны хяналтын тоог баталсан байна.

Хүснэгт 9: Салбар сургуульд элсүүлэх оюутны хяналтын тоо


Хичээлийн жил	Нийт хяналтын тоо		Үүнээс, Дорноговь аймгийн иргэд		Элссэн оюутны тоо	Зөрүү
	Эм зүйч	Эм найруулагч	Эм зүйч	Эм найруулагч	Эм найруулагч	
А	1	2	3	4	5	6=2-5
2018-2019	14	45	2	9	9	36
2019-2020	14	75			10	65
2020-2021	15	40	3	6	20	20

Эм найруулагчийн мэргэжлээр 3 жилийн хугацаанд бэлтгэн, дипломын боловсрол олгодог бол, эм зүйч мэргэжлээр суралцах оюутныг эхний 2 жил тухайн орон нутагт хөтөлбөрийн дагуу сургаж, дараагийн жилүүдэд АШУҮИС-д бэлтгэж, бакалаврын боловсрол эзэмшүүлдэг байна.

Эм найруулагчийн мэргэжлээр жилд 40-75 оюутныг элсүүлэх шийдвэр гардаг ч энэ чиглэлээр суралцах оюутны тоо харьцангуй бага байна. Тухайлбал: 2017 онд 13, 2018 онд 7, 2019 онд 10, 2020 онд 7, 2021 онд 9 оюутан эм найруулагчаар төгссөн байна.

Энэ мэргэжлийг сонгон суралцахгүй байгаа шалтгааныг тус салбар сургуульд сувилахуйн болон их эмчийн ангийн суралцдаг нийт 20 оюутнаас нээлттэй санал асуулгын хуудсаар асуулга явуулж, ярилцлага хийсэн.

График 1. Асуулгын үр дүн



Дээрх графикаас харахад, нийт асуулгад оролцсон оюутнуудын 7 нь буюу 35 хувь нь эмзүйн мэргэжлийг сонгон суралцах хүсэлтэй байгаа гэж хариулсан ба эдгээр оюутнуудаас яагаад энэ мэргэжлээр суралцаагүй байгаа шалтгааныг тодруулахад цаашид сурна, төрөөс тэтгэлэгт хамруулах шаардлагатай, ажлын байр хомс, энэ талаарх мэдээлэл бага байдаг гэсэн тайлбарыг өгч байсан. Орон нутагт тус мэргэжлийн хүний нөөцийн дутагдалтай байгаа асуудлыг хэрхэн шийдвэрлэвэл зохих талаар асуулга авахад төрөөс оюутны сургалтын төлбөрийг хөнгөлөх арга хэмжээ авах, мэргэжлийн талаар мэдээлэл, сурталчилгааг ерөнхий боловсролын сургууль төгсөгчдөд явуулах гэсэн хариултыг нийт оюутны 60 хувь нь өгсөн байна.

АШУҮИС-ийн Дорноговь салбар сургууль нь 2017 оноос эхлэн эрүүл мэндийн салбарын дипломын боловсролтой мэргэжилтнийг 1.5 жилээр суралцуулж, 2018 онд 17, 2021 онд 12 эм найруулагчийг бэлтгэсэн байна.

Дорноговь аймагт дээрх 1.5 жилээр суралцах хөтөлбөрөөр 2020 оноос эм найруулагчийн ангид оюутан элсүүлээгүй бөгөөд дээд шатны байгууллагаас элсэлтийг дахин авахгүй байх чиглэл өгсөн талаар салбар сургууль болон АЗДТГ-ын холбогдох албан тушаалтан тайлбарлав.

Мөн орон нутагт энэ хөтөлбөрийн дагуу эм найруулагч мэргэжлээр суралцах сонирхолтой, эрүүл мэндийн чиглэлээр дипломын боловсрол эзэмшсэн мэргэжилтэн нэлээд байгааг онцолж байлаа.

Аймгийн Засаг даргын 2016 оны А/573 дугаар тушаалаар батлагдсан “Төрөөс эмийн талаар баримтлах бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх нийтлэх журам”-ын 2.6-д “Аймгийн эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн бодлогод эм зүйн мэргэжилтнүүдийг хамруулж, боловсон хүчин бэлтгэхэд... Эрүүл мэндийн газар, орон нутгийн удирдлагын зүгээс дэмжлэг үзүүлнэ” гэж заасан байна.

Дорноговь аймгийн Засаг дарга, БНХАУ-аас Замын-Үүдэд суугаа Ерөнхий консултай хамтран ажиллах чиглэлийн хүрээнд ерөнхий консулаас эм найруулагчийн мэргэжлээр суралцах 20 оюутны сургалтын төлбөрт дэмжлэг үзүүлсэн байна.

Сургалтын төлбөрийн дэмжлэгт хамрагдах оюутны судалгааг боловсруулахдаа аймгийн сум тус бүрээс болон аймгийн төвийн баг бүрээс санал авч, 7 сум болон аймгийн төвийн 5 багаас оюутнуудыг сургаж байна. АЗДТГ ба оюутны хооронд

байгуулсан сургалтын гэрээнд суралцагч нь сургуулиа төгсөөд тухайн орон нутгийн эрүүл мэндийн байгууллагад 3-аас доошгүй жил ажиллах тухай тусгасан байна.

Эмзүйн мэргэжилтнийг бэлтгэхэд орон нутгийн зүгээс дэмжлэг үзүүлсэн боловч хүний нөөцийн дутагдлыг арилгах зорилгоор тус арга хэмжээг цаашид үргэлжлүүлэх шаардлагатай байна.

Тус сургуулийн эм найруулагчийн мэргэжлийн сургалтын төлөвлөгөөг АШУҮИС-ийн захирлын тушаалаар баталдаг байна.

Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3.4-т “*мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг дор дурдсан хугацаагаар эрүүл мэндийн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн олгоно: эм зүйч, эм найруулагчид эм барих үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 5 жилийн хугацаагаар*” гэж тусгасан байна.

Аймгийн Эрүүл мэндийн газраас нийт 113 эмийн мэргэжилтний судалгааг ирүүлсэн ба эм барих үйл ажиллагаа эрхлэх хугацаа дууссан зөвшөөрөл бүртгэгдээгүй байна.

“MNS 5260:2015 Эмийн санд тавих нийтлэг шаардлага”-ын 7.3-т “*Нийтийн үйлчилгээтэй эмийн сангийн мэргэжлийн хүн хүчин нь эмзүйн шинжлэх ухааны, нийгмийн эрүүл мэндийн, ёс зүйн чиглэлээр тасралтгүй сургалтад хамрагдсан байна*” гэж заасан байна.

Багц цагийн сургалтад эм найруулагч болон эм зүйчид 2018-2019 онуудад хамрагдаж, 2020 онд цар тахлын улмаас сургалт зохион байгуулагдаагүй байна.

ЭМСС-ын 2015 оны 98 дугаар тушаалаар батлагдсан “Эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, нөхөн олгох, хүчингүй болгох журам”-д эм зүйн мэргэжилтний багц цагийн бүрдүүлэлтийг ЭМГ-т нэгтгэн бүртгэж байхаар заасан ч багц цагийн сургалтын бүртгэл 2017 оноос хойш цахим хэлбэрт шилжсэнтэй холбоотойгоор эмийн мэргэжилтний багц цаг бүрдүүлэлтийн судалгаа хийгдээгүй байна.

Б. ТӨРӨӨС ЭРҮҮЛ МЭНДИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ БОЛОН ЭМИЙН ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭГ ТӨЛӨВШҮҮЛЭХ АЖЛЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

Б.1 Төрөөс эмийн талаар баримтлах бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх бодлогын баримт бичгийг боловсруулж, хэрэгжүүлсэн боловч хэрэгжилтийг үнэлээгүй байна.

Б.1.1 Төрөөс эмийн талаар болон эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх дэд хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан, баталсан байна.

Улсын Их Хурлын 2014 оны 57 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс эмийн талаар баримтлах бодлого”-ын 1.2-т бодлогын хэрэгжих хугацааг 2014-2018 онд хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Эмийн талаар орон нутагт баримтлах бодлого”-ыг боловсруулахаар тусгажээ. Тус зорилт болон УИХ-аас баталсан дээрх бодлогын баримт бичгийг үндэслэн бодлогыг хэрэгжүүлэх нийтлэг журмыг аймгийн Засаг даргын 2016 оны А/573 дугаар тушаалаар баталсан байна.

Засгийн газрын 2017 оны 24 дүгээр тогтоолоор “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого”-ыг баталж, бодлогыг 2018-2020 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/443 дугаар тушаал, 2020-2026 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/103 дугаар тушаалаар баталсан байна.

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Эрүүл мэндийн талаар баримтлах орон нутгийн бодлого”-ыг боловсруулахаар тусгаж, ЗГ-аас баталсан дээрх бодлоготой уялдуулан ИТХТ-ын 2017 оны 53 дугаар тогтоолоор “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг Дорноговь аймагт хэрэгжүүлэх аймгийн дэд хөтөлбөр”-ийг баталсан байна. Уг дэд хөтөлбөрийн хүрээнд үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан байна.

Орон нутагт хэрэгжүүлэхээр батлагдсан журам болон дэд хөтөлбөр, тэдгээрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний зорилт, арга хэмжээг улсын дээрх бодлогын баримт бичигтэй уялдсан байдлын авч үзэв.

Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын зорилт болон орон нутагт хэрэгжүүлэх нийтлэг журмын зорилтууд нь харилцан уялдаж байна. Төрөөс баримтлах бодлогод тусгагдсан хүний нөөцийг хөгжүүлэх чиглэлийн арга хэмжээг орон нутагт хэрэгжүүлэх журамд тусгаагүй боловч аймгийн ИТХТ-ийн 2018 оны 34 дүгээр тогтоолоор “Дорноговь аймгийн эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хөгжил, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг баталсан байна. Тус хөтөлбөрийг 2018-2020 онуудад хэрэгжүүлэхээр тусгаж, хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулсан байна.

Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогод эм зүйн тусламж үйлчилгээний чиглэлээр тусгагдсан 9 зорилт, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө болон тус бодлогыг Дорноговь аймагт хэрэгжүүлэх аймгийн дэд хөтөлбөр, хөтөлбөрийг 2017-2021 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ, зорилтууд харилцан уялдсан байна.

Б.1.2 Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг жил бүр тайлагнадаг боловч хэрэгжилтийн явцад үнэлгээ хийгдээгүй байна.

“Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг Дорноговь аймагт хэрэгжүүлэх аймгийн дэд хөтөлбөр”-ийг батлах тухай аймгийн ИТХТ-ын 53 дугаар тогтоолын 2-т “...хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг бүтэн жилээр гарган АИТХ-д танилцуулж ажиллахыг аймгийн Засаг даргад үүрэг болгосугай” гэж заасан байна. Эрүүл мэндийн газар жил бүр хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнаж, ЭМЯ болон аймгийн ИТХ-д хүргүүлдэг байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль /тус хууль нь аудитад хамрагдсан онуудад мөрдөгдөж байсан/ -ийн 15 дугаар зүйлийн 15.7-д “Нутгийн захиргааны байгууллага Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг ИТХ-д танилцуулна...” гэж заасан байна.

Мөн ИТХ-аар батлагдсан дэд хөтөлбөрийн 9.1-д “ Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээг Эрүүл мэндийн газар 2 жил тутамд, хөндлөнгийн үнэлгээг 4 жил тутамд хийж, дүнг Эрүүл мэндийн яам болон аймгийн Засаг даргад танилцуулна”, 9.2-т “Эрүүл мэндийн газар нь дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулж...” гэж тусгасан байна.

Аймгийн Засаг даргын тамгын газрын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс эрүүл мэндийн талаар орон нутагт баримтлах бодлогын хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгээгүй байна. Мөн аймгийн ЭМГ-аас бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулаагүй байна.

Б.2 Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх ажил хийгддэг боловч үр дүн хангалтгүй, мэргэжлийн хүний нөөц дутагдалтай байна.

Б.2.1 Жор бичилт болон эмийн олголтод тавих дотоод хяналтын үр нөлөөг үнэлэх боломжгүй байна.

Эмнэлзүйн удирдамж боловсруулах журмыг ЭМС-ын 2013 оны 174 дүгээр тушаалаар баталсан байна. Эмнэлзүйн удирдамжийг төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, ЭМЯ-ны дэргэдэх мэргэжлийн салбар зөвлөл, мэргэжлийн нийгэмлэг, холбоод болон томилогдсон ажлын хэсгүүд боловсруулахаар журамласан байна.

Орон нутгийн хэмжээнд эмнэлзүйн удирдамжийг боловсруулахгүй тул түүнд тавих хяналттай холбоотой асуудлыг энэ асуултын хүрээнд тусгаагүй болно.

Жор бичилтэд тавих хяналт.

ЭМС-ын 2019 оны А/414 дугаар тушаалаар батлагдсан “эмийн эмчилгээг зохицуулах хорооны ажиллах журам”-ын 3.2-т ЭЭЗХ-ны үүргийг тусгасан ба 3.2.12-т “*Жорын маягт, жор бичилтийн стандартын мөрдөлт, жорын маягтын хангалт, хүртээмж, жор бичилтийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах, хяналт тавьж ажиллах*” гэж заасан байна.

Тус аймгийн эрүүл мэндийн байгууллагаас аймгийн нэгдсэн эмнэлэг болон Замын-Үүд сумын нэгдсэн эмнэлгийг түүвэрт хамруулж, жор бичилтэд тавих хяналтыг шалгасан. Эдгээр нэгдсэн эмнэлгийн ЭЭЗХ нь 2018-2020 онуудад дотоод хяналтын төлөвлөгөөг боловсруулж ажилласан ба төлөвлөгөөний дагуу жор бичилтэд хяналт тавьсан байна. Уг ажлын хүрээнд эмийн сангуудаас холбогдох байгууллагын эмч нарын бичсэн жорыг түүвэрчлэн шалгаж, илэрсэн зөрчлийг арилгах, стандартад нийцсэн жорыг бичих ажлыг төлөвшүүлэх зорилгоор эмч нарт сургалт болон жор бичилтийг сайжруулах уралдаан зохион байгуулжээ.

Эмийн жор бичилтэд аймгийн Эрүүл мэндийн газраас хяналт тавих зорилгоор сар бүр жорын талаарх тоон мэдээг эмийн сангуудаас авдаг боловч эмийн сангуудын нийт хүлээн авсан жорын тоо баримт, зөрчлийн талаар нэгтгэсэн судалгааг боловсруулах ажлыг хангалтгүй зохион байгуулсан байна. Аудитын явцад 2018, 2019, 2020 онуудын жорын нэгтгэсэн тоон мэдээ, тэдгээрийн зөрчил дутагдлын талаар нэгтгэсэн баримт материалыг бүрэн ирүүлээгүй байна.

Энэ нь жор бичилтийн стандарт мөрдөлттэй холбоотой илэрсэн алдаа, зөрчлийн статистикийг тодорхойлох, дүн шинжилгээ хийх, жор бичилтэд тавьж буй дотоод хяналт үр дүнтэй зохион байгуулагдаж байгаад үнэлгээ дүгнэлт өгөх боломжгүйд хүргэж байна.

Эм олгох үйл ажиллагаанд тавих хяналт

MNS 5260-2015:Эмийн санд тавих нийтлэг шаардлагын 6.1-д “*Эмийн сангийн ...дотоод хяналтын үйл ажиллагааг зөвхөн эм зүйч гүйцэтгэнэ*” гэж заасан.

Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлгийн даргын 2019 онд баталсан “Эмийн сангийн үйл ажиллагааг зохицуулах журам”-д эм олголтод тавих дотоод хяналтыг эмнэлгийн эмийн сангийн эм зүйч хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн эмчлүүлэгчийн эмийн захиалгыг эмчилгээ эрхэлсэн орлогч дарга хянаж, баталгаажуулдаг ба эм зүйч нь жор баригчийн эмийн олголтод өдөр тутмын хяналтыг хэрэгжүүлж байна. Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлэгт эм олголтод хийх дотоод хяналтыг эм зүйч хэрэгжүүлэн ажиллаж байна.

Нийтийн үйлчилгээтэй эмийн сангийн эм олголтод тавих дотоод хяналтыг эмийн сангийн эрхлэгч-эм зүйч хэрэгжүүлэх чиг үүрэгтэй боловч тус чиг үүргийг хэрэгжүүлсэн эсэхийг нотлох боломжгүй байна. Үүнээс гадна, зарим эмийн сангуудад хүний нөөцийн дутагдалтай байдлаас шалтгаалж нэг мэргэжилтэн ажиллаж байгаа нь эмийн олголтод тавих дотоод хяналтыг хэрэгжүүлэх боломж, нөхцөл бүрдэхгүй байна.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газраас 2018 онд 3 эмийн санд хяналт шалгалт хийсэн ба шалгалтын тайланд жороор олгох эмийг жоргүй олгосон зөрчил эмийн сангуудад илэрсэн байна.

Б.2.2 Эм зүйн ба эмнэлзүйн тусламж, үйлчилгээг үзүүлэх нөхцөл хангалттай бүрдээгүй байна.

Эм зүйн болон эмнэлзүйн тусламж үйлчилгээг үзүүлэх нөхцөлийг хүний нөөцийн хангамж, мэргэжил болон орчны эрүүл ахуйн чиглэлээр тодорхойлсон болно.

2018-2020 онуудад үйл ажиллагаа явуулсан нийтийн үйлчилгээтэй болон эмнэлгийн эмийн сан, эм ханган нийлүүлэх байгууллагад ажилласан хүний нөөцийн хангамжийг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 10: Эмийн мэргэжилтний хүний нөөцийн тоон мэдээлэл

№	Эмийн сан болон ЭХНБ-ын төрөл	2018 он			2019 он			2020 он		
		Байгууллагын тоо	Эм зүйч	Эм найруулагч	Байгууллагын тоо	Эм зүйч	Эм найруулагч	Байгууллагын тоо	Эм зүйч	Эм найруулагч
А	Б	1	2	3	4	5	6	7	8	9
1	Нийтийн үйлчилгээтэй эмийн сан	43	19	61	45	23	58	43	23	57
2	Эмнэлгийн эмийн сан	8	4	8	26	5	7	26	5	8
3	Ханган нийлүүлэх төв	4	4	6	4	6	6	4	5	6
Нийт		55	27	75	75	34	71	73	33	71

Дээрх хүснэгтэд тусгагдсан 2020 онд ажилласан хүн хүчний тоо, мэргэжилтнийг “MNS 5260:2015 Эмийн санд тавигдах нийтлэг шаардлага”-ын А хавсралт, “MNS 5530:2014 Эм, эмнэлгийн хэрэгслийн хадгалалт, түгээлтэд тавих ерөнхий шаардлага”-ын 6.1, 6.2-т заасан шалгуурын дагуу үнэлэв. Хавсралт 2-т стандартад тусгагдсан орон тоо болон 2020 онд ажилласан хүн хүчний хангамжийн судалгааг харуулав.

2020 онд ажилласан мэргэжилтний тоог харьцуулахад нийтийн үйлчилгээтэй эмийн санд эмийн сангийн эрхлэгч 16, нөөцийн тасгийн эм зүйч 9, эм найруулагч 9 дутагдалтай байна.

“MNS 5530:2014 Эм, эмнэлгийн хэрэгслийн хадгалалт, түгээлтэд тавих ерөнхий шаардлага”-ын 6.1, 6.2-т албан тушаалын нэрийг тусгаж өгсөн ба орон тоог хүрэлцэхүйц тооны ажилтан ажиллуулна гэж заасан байна. Тус шалгуурын дагуу хүний нөөцийн хангамжийг үнэлэхэд ЭХНБ-уудад 1-2 орон тооны мэргэжилтэн ажиллаж байна.

Аймгийн болон Замын-Үүд сумын нэгдсэн эмнэлэгт эмийн сангийн эрхлэгчийн орон тоог баталдаггүй, стандартын дагуу аймгийн нэгдсэн эмнэлэг 4-5 клиник эм зүйчийн орон тоотой ажиллах байтал 1 эм зүйч, Замын-Үүд сумын нэгдсэн эмнэлэг стандартын дагуу 2 клиник эм зүйчийн орон тоотой ажиллах байтал 1 эм зүйч ажиллаж байна.

Сум дундын эмнэлэг, өрхийн болон сумын ЭМТ-ийн 21 эмийн сан үйл ажиллагаа явуулж байгаа ба 2021 оны байдлаар 8 сумын ЭМТ, 4 өрхийн ЭМТ, сум дундын 1 эмнэлэгт эмийн мэргэжилтэн дутагдалтай байна.

Мөн 2020 онд хувийн хэвшлийн ортой 5 эмнэлэг үйл ажиллагаа явуулсан ба стандартад заасан орон тооноос эмийн сангийн эрхлэгч 5, нөөцийн тасгийн эрхлэгч 5, клиник эм зүйч 5, жор баригч 2 дутагдалтай байна.

Аудитын явцад нийт 13 байгууллагын эмийн сангийн стандартын хэрэгжилтийг асуулгын хуудсаар шалгасан ба үр дүнг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 11: **Стандартын хэрэгжилтийн хяналт, шалгалтын мэдээлэл**

№	Эмийн сангийн төрөл	Хамрагдсан байгууллагын тоо	Шалгуур үзүүлэлтийн тоо ¹	Илэрсэн зөрчлийн тоо ²
А	Б	1	2	3
1	Нэгдсэн эмнэлэг	2	30	19
2	Сумын ЭМТ	2	13	12
3	1 дүгээр зэрэглэлийн эмийн сан	2	28	8
4	2 дугаар зэрэглэлийн эмийн сан	7	20	52
Нийт		13	91	91

Тайлбар¹ - Нэг байгууллагыг шалгахад ашигласан шалгуур үзүүлэлтийн тоо

Тайлбар² - Хамрагдсан байгууллагуудын зөрчлийн нийт тоо

Шалгалтын явцад дараах нийтлэх зөрчил илэрлээ. Үүнд:

- Эмийн сангийн ажилтан эмнэлгийн үзлэгт хамрагдаагүй,
- Эмийн сургалт сурталчилгаатай холбоотой бүртгэлийг хийгээгүй,
- Нян устгах гэрэлгүй, гэрэл эвдэрсэн,
- Термометр, чийг хэмжигч байхгүй, баталгаажуулаагүй,
- Зөрчилтэй жорын бүртгэлийг хөтөлдөггүй,
- Эмийн сангийн үйлчлэгчийн орон тоо сул, үйлчлэгчийг ажиллуулаагүй.

Зураг 2: Нийтийн үйлчилгээтэй эмийн сан



Сумын ЭМТ-ийн эмийн сангийн өрөө тасалгаа, эм хадгалах шүүгээ зэрэг нь стандартын шаардлага хангахгүй байв.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газраас 2018 онд явуулсан стандартын хэрэгжилтийн шалгалтад эм хангамжийн 7 байгууллагыг хамруулсан ба дараах нийтлэг зөрчил, дутагдал илэрсэн байна. Үүнд,

- Дотоод хяналт хангалтгүйгээс эм хүлээн авах, хадгалах, устгах журамгүй,
- Эмийг жорын дагуу олгох үйл ажиллагаа дутагдалтай,
- Зориулалтын тээврийн хэрэгсэлгүй, агаар сэлгэх төхөөрөмж хангалтгүй,
- Эмийн чанар, аюулгүй байдалд тавих дотоод хяналт, дотоод зохион байгуулалт хангалтгүй,
- Хүний нөөц дутагдалтай.

Эм зүйн тусламж үйлчилгээг үзүүлэх нөхцөл стандартын шаардлагыг хангахгүй байгаа нь орон нутагт эм зүйн мэргэжлийн хүний нөөцийн дутмаг байдал, төсөв, санхүүгийн хүрэлцээгүй нөхцөл, ажилтан, албан хаагчийн хариуцлагагүй байдалтай холбоотой байна.

Б.2.3 Эмийн зохистой хэрэглээг иргэдэд сурталчлах ажлыг тогтмол зохион байгуулдаг ч хамрах хүрээг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

УИХ-ын 2014 оны 57 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс эмийн талаар баримтлах бодлого”-ын 6 дугаар зүйлийн 6.3.3-т “эмийн зохистой хэрэглээний талаар хэрэглэгчийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх”, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2-т “Эмч эмийн...хэрэглэх арга, хугацаа, илрэх гаж нөлөө зэргийг үйлчлүүлэгчид тайлбарлана”, 17.3-т “Эмийн мэргэжилтэн эмийн сангаас эм олгоходоо хэрэглэх арга, хадгалах нөхцөл, зохистой хэрэглээний талаар иргэдэд зөвлөгөө өгнө” гэж тус тус заасан байна.

Аймгийн ЭМГ-аас “Антибиотикийг жорын дагуу хэрэглэе, антибиотикийн даслаас урьдчилан сэргийлье” нэртэй сарын аяныг жил бүр зохион байгуулсан байна. Уг ажлын хүрээнд эмийн зохистой хэрэглээг иргэдэд сурталчлах арга хэмжээг зохион байгуулах талаар зөвлөмж, чиглэлийг орон нутагт үйл ажиллагаа явуулдаг эрүүл мэндийн болон эм хангамжийн байгууллагад хүргүүлсэн байна. Иргэдэд эмийн зохистой хэрэглээний талаар сургалт, сурталчилгааг явуулсан байгууллагаас хэрэгжилтийн тайлан, мэдээг ЭМГ-т ирүүлсэн байна. Дараах хүснэгтэд сургалтын талаарх тоон мэдээллийг тусгав.

Хүснэгт 12: Иргэдэд зориулан явуулсан сургалтын мэдээлэл


Он	Сургалт зохион байгуулсан байгууллагын тоо	Сургалтын тоо	Хамрагдсан иргэдийн тоо
А	1	2	3
2018	4	71	1,179
2019	20	57	2,902
2020	24	55	3,612
Нийт	48	183	7,693

ЭМГ нь эрүүл мэндийн болон эм хангамжийн байгууллагаас ирүүлсэн сургалтын мэдээ, тайлангийн үзүүлэлтийг нэгтгээгүй, тайлан мэдээг архивлах ажил хангалтгүй хийгдсэн байна.

Аймгийн ЭМГ-аас эмийн зохистой хэрэглээг орон нутгийн олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажлыг явуулсан талаар байгууллагын үйл ажиллагааны тайланд тусгасан байна.

ЭМГ болон зарим эрүүл мэндийн байгууллага, эмийн сан нь эмийн зохистой хэрэглээний талаар сурталчилгааны ажлыг өөрийн цахим хуудас болон facebook хаягт байршуулсан сайн туршлагатай байна.

Зураг 3: Эмийн зохистой хэрэглээ



Иргэдэд эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх ажлын үр дүнг үнэлэх зорилгоор аудитын явцад Сайншанд, Замын-Үүд сумдын эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа өвчтөн, эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлж байгаа иргэд, төрийн болон хувийн хэвшлийн албан байгууллагын ажилтан, албан хаагч зэрэг нийт 131 иргэнээс асуулгыг цаасаар авсан ба docs.google.com хуудаст байршуулсан тус асуулгад 19 иргэн оролцож, нийт 150 иргэнийг асуулгад хамруулсан болно.

Асуулгад эмийн зохистой хэрэглээний талаарх мэдлэг, мэдээлэлтэй байгаа эсэх болон мэдээллийг ямар эх сурвалжаас авдаг, энэ чиглэлээр сургалтад хамрагдаж байсан эсэхийг тодруулах зорилготой дараах 4 асуултыг тусгасан.

1.Эмийн зохистой хэрэглээний талаар мэдлэг, мэдээлэлтэй байдаг уу гэсэн асуултад нийт асуулгад хамрагдсан иргэдийн 90 буюу 60 хувь нь “Тийм”, 60 иргэн буюу 40 хувь нь “Үгүй” гэж хариулсан байна.

2.Эмийн зохистой хэрэглээний талаар мэдээллийг олж авдаг эх сурвалжийг тодорхойлох олон сонголт бүхий хариулттай асуултад давхардсан тоогоор 210 хариулт ирсэн. Эмийг зохистой хэрэглэх заавар, зөвлөгөө, мэдээллийг эмийн сангийн мэргэжилтнээс 36.6 хувь, эмчээс 36 хувь, хэвлэл мэдээлэл, олон нийтийн мэдээллийн хэрэгслээс 31 хувь, цахим мэдээллийн сүлжээ, хэрэгслээс 34 хувь, бусад эх сурвалжаас 6 хувь, энэ талаарх мэдээллийг олж авдаггүй гэж 5.3 хувь хариулсан байна.

График 2: Эмийн зохистой хэрэглээний талаар мэдээллийн эх сурвалж, (хариултын тоогоор)



3. Эмийн зохистой хэрэглээний талаарх сургалтад хамрагдаж байсан эсэх гэсэн асуултад нийт оролцогчдын 10.6 хувь нь “Тийм”, 89.4 хувь нь “Үгүй” гэж хариулсан.

4. Эмийн сангийн ажилтан эмийн хэрэглэх зааврыг ойлгомжтой тайлбарлаж өгдөг үү гэсэн асуултад нийт оролцогчдын 82 хувь нь “Тийм”, 18 хувь нь “Үгүй” гэж хариулсан.

График 3: Эмийн зохистой хэрэглээний талаарх асуулгын дүн, (хариултын тоогоор)



Дээрх асуулгын үр дүнгээс харахад асуултад оролцогчдын ихэнх хувь нь эмийн зохистой хэрэглээний ойлголт, мэдээлэл байдаггүй, энэ чиглэлээр зохион байгуулсан сургалтад хамрагдаж байгаагүй гэсэн хариултыг өгсөн байна.

Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгааг жил бүр тогтмол зохион байгуулдаг боловч хамрах хүрээг нэмэгдүүлж, үр дүнг үнэлэн ажиллах шаардлагатай байна.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. Төрөөс баримтлах эмийн болон эрүүл мэндийн бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх төлөвлөгөө, хөтөлбөрийг баталсан боловч хэрэгжилтийг үнэлэх ажлыг зохион байгуулаагүй байна.
2. Нийтийн үйлчилгээтэй эмийн сангийн ЗШЭ-ийн нөөц хангалтгүй байна.
3. Эм, эмнэлгийн хэрэгслийн удирдлагын мэдээллийн системийг хөгжүүлэх ажил удаашралтай байгаагаас цахимаар эмийн бүртгэл, хяналтыг хэрэгжүүлэх боломжгүй байна.
4. Эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлттэй эмийн жагсаалтад орсон эмийн зардалд 2018-2020 онд жилд дунджаар 758.3 сая төгрөгийг олгосон байна.
5. Улсын төсвөөс эмийн зардалд 2020 онд 2,942.2 сая төгрөгийг олгосон ба 2018 оны санхүүжилтийн дүнтэй харьцуулахад 47 хувиар өссөн байна.
6. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах зардлын төсөв хүрэлцээгүйгээс 2019 онд 281.6 сая төгрөг, 2020 онд 82.0 сая төгрөгийн өглөгтэй ажилласан байна.
7. Өндөр өртөгтэй, санхүүгийн дарамт үүсгэх эмнэлгийн хэрэгсэлд болон ядуу, эмзэг бүлгийн хүн амд 2018-2020 онуудад төрөөс дэмжлэг үзүүлээгүй байна.
8. ЭМГ-аас эм зүйн болон эрүүл мэндийн салбарын байгууллагуудтай байгуулсан гэрээ, санамж бичигт тусгасан арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэх ажил хангалтгүй байна.
9. Эмзүйн хүний нөөцийг бэлтгэх зорилгоор 2020 онд тус аймгийн 20 оюутны сургалтын төлбөрт дэмжлэг үзүүлэн гэрээ байгуулж, АШУҮИС-ийн Дорноговь салбар сургуульд бэлтгэж байна.
10. Эмзүйн мэргэжилтнийг бэлтгэхэд орон нутгийн зүгээс дэмжлэг үзүүлсэн боловч хүний нөөцийн дутагдлыг арилгах зорилгоор тус арга хэмжээг цаашид үргэлжлүүлэх шаардлагатай байна.
11. Жор бичилтийн стандарт мөрдөлт болон эм олгох үйл ажиллагаанд тавьсан хяналт шалгалт, илэрсэн зөрчлийн талаарх баримт, материал хангалтгүй байгаа тул хяналтын үр дүнг үнэлэх боломжгүй байна.
12. Мэргэжлийн хүн хүчний дутмаг байдал, төсөв санхүүгийн хүрэлцээгүй байдлаас шалтгаалж эм зүйн тусламж үйлчилгээ үзүүлэх нөхцөл хангалттай бүрдээгүй байна.
13. Эмийн зохистой хэрэглээг иргэдэд сурталчлах ажлыг шат шатны эрүүл мэндийн болон эм хангамжийн байгууллагууд зохион байгуулж байгаа боловч хамрах хүрээг нэмэгдүүлж, үр дүнг сайжруулах шаардлагатай байна.
14. Аймгийн ЭМГ нь эрүүл мэндийн болон эм хангамжийн байгууллагуудаас сарын мэдээ тайлан, сургалт, сурталчилгааны тайлан бүрэн аваагүй, ирүүлсэн тайлан, мэдээг архивлах, нэгтгэх ажлыг хангалтгүй зохион байгуулсан байна.
15. Аймгийн ИТХТ-ийн 2017 онд баталсан “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг Дорноговь аймагт хэрэгжүүлэх аймгийн дэд хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийгээгүй байна.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд нийт 6 зөвлөмжийг холбогдох 2 албан тушаалтанд хүргүүлэв.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт, нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ УЛАМЖЛАХ НЬ:

1. Сумын ЭМТ-ийн эмзүйн тусламж, үйлчилгээг стандартад заасан шаардлагын дагуу үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх,
Тайлбар: Тус асуудлыг тайлангийн дүнгийн хэсгийн Б.2.2-т тусгасан болно.
2. Зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад тусгагдсан эмийн нэр төрлийг эмийн сангийн зэрэглэлтэй уялдуулан боловсруулах чиглэлээр дүн шинжилгээ хийх,
Тайлбар: Тус асуудлыг тайлангийн дүнгийн хэсгийн А.1.1-т тусгасан болно.
3. Эмийн бүртгэл, мэдээлэл, орлого, зарлага, гаж нөлөө зэрэг мэдээллийг агуулсан удирдлагын системийг боловсруулах ажиллагааг эрчимжүүлж, цахим систем, программ хангамжийн ашиглалтыг сайжруулах.
Тайлбар: Тус асуудлыг тайлангийн дүнгийн хэсгийн А.1.3-т тусгасан болно.

Дээрх саналыг холбогдох байгууллагад уламжилж өгнө үү.


АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА О.БАТЖАРГАЛ ТАНАА:

1. Орон нутагт дутагдалтай байгаа эм зүйн мэргэжлийн хүний нөөцийг бэлтгэх, нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх,
2. “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг Дорноговь аймагт хэрэгжүүлэх дэд хөтөлбөр”-ийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх

АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА Г.ЭНХЦЭЦЭГ ТАНАА:

1. Төрийн өмчит эрүүл мэндийн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, байгуулсан гэрээний хэрэгжилтийг үнэлэх шалгуурт эмийн хангалт, чанар, аюулгүй байдалтай холбоотой үзүүлэлтийн тусгах,
2. Эмийн жор бичилтийг стандартын дагуу гүйцэтгэх үйл ажиллагааг сайжруулах зорилгоор жорын мэдээг нэгтгэн, дүн шинжилгээ хийж, холбогдох байгууллагад жор бичилтийн стандартыг мөрдүүлэх арга зүйн зөвлөмжийг хүргүүлэх ажлыг зохион байгуулах.
3. Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх чиглэлээр иргэдэд зориулан хийгдсэн сургалт, сурталчилгааны баримт материалыг холбогдох байгууллагаас авч, нэгтгэн, сургалтын үр дүнг сайжруулах ажлыг зохион байгуулах.
4. “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг Дорноговь аймагт хэрэгжүүлэх дэд хөтөлбөр”-ийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулах.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:



**ДОРНОГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум, 3 дугаар баг,
Нутгийн удирдлагын ордон, Утас: 7052 2533,
Факс: (976) 7052 2530, И-мэйл: zdtg@dornogovi.gov.mn,
Вэбсайт: dornogovi.gov.mn

2021.11.04 № 01/1365

танай _____-ны № _____-т

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Т.ГАН-ӨЛЗИЙ ТАНАА

“Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын
хэрэгжилт, үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудитын
тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тайлангийн төсөлтэй холбоотой санал
байхгүй болно.



О.БАТЖАРГАЛ

44 6211484

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР
131 байр, Эрүүл мэндийн гудамж, 2 дугаар баг,
Сайншанд сум, Дорноговь, 44105
Утас/факс: (705) 2-23-49
И-мэйл: emg.dornogovi@gmail.com


2021.11.04 № 1311


танай _____-ны № _____-т

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
Т.ГАН-ӨЛЗИЙ ТАНАА

“Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, үр нөлөө” гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана, тайланд оруулах санал үгүй.


ДАРГА  Г.ЭНХЦЭЦЭГ



My Dok.D.toot 2021


АУДИТЫГ ГҮЙЦЭТГЭСЭН БАГИЙН ГИШҮҮД :

Аудитор:




Ч.Хэрлэнчимэг

Аудитор:



Б.Ариунбаатар

Гэрээт аудитор:



М.Дүүрэнжаргал


ХЯНАСАН:

Аудитын менежер:



У.Оюунтүлхүүр

Дарга, тэргүүлэх аудитор:



Т.Ган-Өлзий

**АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХАМТРАН ОРОЛЦСОНД
ТАЛАРХАЛ ИЛЭРХИЙЛБЕ.**

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ:



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ**

2021 оны 11 сарын 04 өдөр

Дугаар А/32

Дорноговь аймаг, Сайншанд сум

**Гүйцэтгэлийн аудитын тайлан
баталгаажуулах тухай**

Монгол Улсын Төрийн Аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 9 дүгээр зүйлийн 9.1, 20 дугаар зүйлийн 20.1, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/207 дугаар “Эрх, үүрэг шилжүүлэх тухай” тушаалын 5 дугаар хавсралтын 1.3, 2.4, 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18.9, 2021 оны А/28 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын 2021 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-нд тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, биелэлтийг 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлэхийг аймгийн Засаг дарга, аймгийн Эрүүл мэндийн газрын дарга нарт тус тус зөвлөсүгэй.

3. Аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймгийн Засаг дарга, аймгийн Эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналтын газрын дарга, “Эм” холбооны Дорноговь аймаг дахь салбар зөвлөлийн тэргүүн нарт хүргүүлсүгэй.

4. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер У.Оюунтүлхүүр/-т даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

010010180




Зайлшгүй шаардлагатай эмийн нөөцийн хангалтын хувь /2020 оны байдлаар/

№	Эмийн бүлгийн нэр	70-с дээш	60-69 хувь	50-59 хувь	40-49 хувь	30-39 хувь	30-оос доош хувь
1	Мэдээгүйжүүлэх бэлдмэл	72.5%					
2	Өвдөлт намдаах, халуун бууруулах, үрэвслийн эсрэг эм		63.2%				
3	Харшлын ба анафилаксийн эсрэг эм	77.1%					
4	Антидотууд ба хордлого тайлах эм		65.6%				
5	Уналт, таталтын эсрэг эм						29.5%
6	Халдварын эсрэг эм					37.8%	
7	Мигрень эмчлэх эм						0.0%
8	Хавдрын эсрэг, дархлал дарангуйлах, хөнгөвчлөх эмчилгээний эм						1.5%
9	Салга овчнийг эмчлэх эм						25.0%
10	Цусанд нөлөөлөх эм		61.8%				
11	Цусны бэлдмэл, сийвэн орлох эм				46.4%		
12	Зүрх судасны эм				46.9%		
13	Арьсны овчнийг эмчлэх бэлдмэл				43.4%		
14	Халваргүйжүүлэх ба үжлийн эсрэг бодис	91.9%					
15	Бөөр шээсний замд нөлөөлөх эм		62.4%				
16	Ходоод, гэдэсний замын овчнийг эмчлэх эм			53.8%			
17	Даавар, дааврын үйлдэлт бусад бэлдмэл ба жирэмслэлтээс сэргийлэх					34.7%	
18	Дархлалын системд нөлөөлөх бэлдмэл					36.8%	
19	Булчин сулруулах ба холинэстеразийн эсрэг бэлдмэл	80.0%					
20	Нүдний өвчинд хэрэглэх бэлдмэл				49.0%		
21	Окситоцин ба түүний эсрэг бэлдмэлүүд						18.6%
22	Сэтгэцийн болон зан үйлийн эмгэгийг эмчлэх эм					34.0%	
23	Амьсгалын замын үйл ажиллагаанд нөлөөлөх эм			52.7%			
24	Давс, ус, хүчил, шүлтийн тэнцэвэрт нөлөөлөх эм		65.2%				
25	Аминдэм, эрдэс бодис	75.3%					
	Нийт эмийн бүлгийн тоо	5	5	2	4	4	5

Тайлбар: ЗШЭ-ийн дундаж хувийг Замын-Үүд, Сайншанд сумдад үйл ажиллагаа явуулдаг 24 нийтийн үйлчилгээтэй эмийн сангийн нөөцийн мэдээлэлд үндэслэн боловсруулсан болно.

“Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудит



ЭМИЙН САНГИЙН ХҮН ХҮЧНИЙ ХАНГАЛТ /2020 оны байдлаар/

№	Эмийн сангийн нэр	Үйл ажиллагаа явуулдаг байршил, сум	Зэрэглэл	Стандартын дагуу байвал зохих						Ажиллаж байгаа						Зөрүү									
				Эмийн сангийн эрхлэгч	Эм шинжлэгч	Нөөцийн тасгийн эм зүйч	Клиник эм зүйч	Жор баригч	Эм найруулгач	Шил угаагч	Эмийн сангийн эрхлэгч	Эм шинжлэгч	Нөөцийн тасгийн эм зүйч	Клиник эм зүйч	Жор баригч	Эм найруулгач	Шил угаагч	Эмийн сангийн эрхлэгч	Эм шинжлэгч	Нөөцийн тасгийн эм зүйч	Клиник эм зүйч	Жор баригч	Эм найруулгач	Шил угаагч	
Нийтийн эмийн сан																									
1	"Тана-Эрдэнэ" эмийн сан	Айраг сум	2	1	X	X	X	1	X	X	1	X	X	X	1	X	X	-	X	X	X	-	X	X	
2	"Анагаах увидас" эмийн сан	Алтанширээ сум	2	1	X	X	X	1	X	X	-	X	X	X	1	X	X	1	X	X	X	-	X	X	
3	"Сүгмэл" эмийн сан	Даланжаргалан сум	2	1	X	X	X	1	X	X	-	X	X	X	1	X	X	1	X	X	X	-	X	X	
4	"Авралын булаг" эмийн сан	Дэлгэрэх сум	2	1	X	X	X	1	X	X	1	X	X	X	1	X	X	-	X	X	X	-	X	X	
5	"Анагаах тана" эмийн сан	Иххэт сум	2	1	X	X	X	1	X	X	1	X	X	X	1	X	X	-	X	X	X	-	X	X	
6	"Хорго сайхан" эмийн сан	Мандах сум	2	1	X	X	X	1	X	X	-	X	X	X	1	X	X	1	X	X	X	-	X	X	
7	"Орвон сухай" эмийн сан	Өргөн сум	2	1	X	X	X	1	X	X	-	X	X	X	1	X	X	1	X	X	X	-	X	X	
8	"Эрдэнийн тун" эмийн сан	Сайхандулаан сум	2	1	X	X	X	1	X	X	-	X	X	X	1	X	X	1	X	X	X	-	X	X	
9	"Гэргэн" эмийн сан	Улаанбадрах сум	2	1	X	X	X	1	X	X	-	X	X	X	1	X	X	1	X	X	X	-	X	X	
10	"Энх тун" эмийн сан	Хатанбулаг сум	2	1	X	X	X	1	X	X	-	X	X	X	1	X	X	1	X	X	X	-	X	X	
11	"Хос рашаант" эмийн сан	Хөвсгөл сум	2	1	X	X	X	1	X	X	1	X	X	X	1	X	X	-	X	X	X	-	X	X	
12	"Алгат сан" эмийн сан	Эрдэнэ сум	2	1	X	X	X	1	X	X	1	X	X	X	1	X	X	-	X	X	X	-	X	X	
13	"Баян бошигт" эмийн сан	Зүүнбаян	2	1	X	X	X	1	X	X	1	X	X	X	1	X	X	-	X	X	X	-	X	X	
14	ЭЭС салбар эмийн сан	Замын-Үүд сум	2	1	X	X	X	1	X	X	1	X	X	X	1	X	X	-	X	X	X	-	X	X	
15	"Бахлаг тун" эмийн сан	Сайншанд, 3-р баг	1	1	X	1	X	1	1	1	-	X	-	X	1	1	1	-	1	X	1	X	-	1	1
16	Олон-Овоо багийн эмийн сан	Даланжаргалан сум	2	1	X	X	X	1	X	X	-	X	X	X	1	X	X	1	X	X	X	-	X	X	
17	"Баян тун" эмийн сан	Сайншанд, 4-р баг	2	1	X	X	X	1	X	X	1	X	X	X	1	X	X	-	X	X	X	-	X	X	
18	"Шандфарм" эмийн сан	Сайншанд, 2-р баг	2	1	X	X	X	1	X	X	1	X	X	X	1	X	X	-	X	X	X	-	X	X	
19	"Монос"-1 эмийн сан	Сайншанд, 2-р баг	1	1	X	1	X	1	1	1	1	X	-	X	1	-	-	-	X	1	X	-	1	1	
20	"Монос"-2 эмийн сан	Сайншанд, 3-р баг	2	1	X	X	X	1	X	X	1	X	X	X	2	X	X	-	X	X	X	-1	X	X	
21	"Брайвум" эмийн сан	Сайншанд, 4-р баг	1	1	X	1	X	1	1	1	1	X	-	X	1	-	-	-	X	1	X	-	1	1	
22	"Увдаст тан" эмийн сан	Сайншанд, 4-р баг	2	1	X	X	X	1	X	X	-	X	X	X	1	X	X	1	X	X	X	-	X	X	
23	"Гайхамшигт тун" эмийн сан /24 цаг/	Сайншанд, 2-р баг	1	1	X	1	X	3	1	1	-	X	-	X	3	-	-	-	1	X	1	X	-	1	1
24	"Түүн хөх" эмийн сан	Сайншанд, 1-р баг	2	1	X	X	X	1	X	X	1	X	X	X	1	X	X	-	X	X	X	-	X	X	
25	Дорноговь эм хангамж 1-р эмийн сан	Сайншанд, 2-р баг	1	1	X	1	X	1	1	1	1	X	-	X	1	-	-	-	X	1	X	-	1	1	
26	Дорноговь эм хангамж 2-р эмийн сан	Сайншанд, 2-р баг	1	1	X	1	X	1	1	1	1	X	-	X	1	-	-	-	X	1	X	-	1	1	
27	"Ганга фарм" эмийн сан	Сайншанд, 2-р баг	1	1	X	1	X	1	1	1	1	X	-	X	1	-	-	-	X	1	X	-	1	1	
28	"Хүслийн мөнгөн үүд" эмийн сан	Замын-Үүд, 1-р баг	2	1	X	X	X	1	X	X	1	X	X	X	1	X	X	-	X	X	X	-	X	X	
29	"Төгөлдөр фарм" эмийн сан	Замын-Үүд, 1-р баг	1	1	X	1	X	1	1	1	1	X	1	X	1	-	-	-	X	-	X	-	1	1	
30	"Долгион" эмийн сан	Замын-Үүд, 2-р баг	2	1	X	X	X	1	X	X	1	X	X	X	2	X	X	-	X	X	X	-1	X	X	
31	"Мандах нар" эмийн сан	Замын-Үүд, 1-р баг	1	1	X	1	X	1	1	1	1	X	1	X	1	-	-	-	X	-	X	-	1	1	
32	"Түшиг" эмийн сан	Сайншанд, 3-р баг	2	1	X	X	X	1	X	X	1	X	X	X	2	X	X	-	X	X	X	-1	X	X	
33	"Төгөл" эмийн сан	Замын-Үүд, 1-р баг	2	1	X	X	X	1	X	X	1	X	X	X	2	X	X	-	X	X	X	-1	X	X	
34	"Гайхамшигт тан" эмийн сан	Сайншанд, 2-р баг	2	1	X	X	X	1	X	X	-	X	X	X	1	X	X	1	X	X	X	-	X	X	
35	"Фарма маркет" эмийн сан	Сайншанд, 3-р баг	1	1	X	1	X	1	1	1	1	X	-	X	1	-	-	-	X	1	X	-	1	1	
36	"Сайн" эмийн сан	Замын-Үүд, 2-р баг	2	1	X	X	X	1	X	X	1	X	X	X	1	X	X	-	X	X	X	-	X	X	
37	"Наран" эмийн сан	Хатанбулаг, 5-р баг	2	1	X	X	X	1	X	X	-	X	X	X	1	X	X	1	X	X	X	-	X	X	
38	"Монос Дорноговь" эмийн сан	Айраг сум	2	1	X	X	X	1	X	X	1	X	X	X	1	X	X	-	X	X	X	-	X	X	
39	"Дөлгөөн од фарма" эмийн сан	Сайншанд, 2-р баг	1	1	X	1	X	1	1	1	-	X	-	X	1	1	-	-	1	X	1	X	-	1	1
40	"Бат үндэс" эмийн сан	Сайншанд, 5-р баг	2	1	X	X	X	1	X	X	1	X	X	X	1	X	X	-	X	X	X	-	X	X	
41	"Төгс омбол" эмийн сан /24 цаг/	Сайншанд, 3-р баг	2	1	X	X	X	3	X	X	1	X	X	X	2	X	X	-	X	X	X	1	X	X	
42	"Төгс ох" эмийн сан	Сайншанд, 2-р баг	2	1	X	X	X	1	X	X	-	X	X	X	1	X	X	1	X	X	X	-	X	X	
43	"Агь фарма" эмийн сан	Замын-Үүд сум	2	1	X	X	X	1	X	X	-	X	X	X	1	X	X	1	X	X	X	-	X	X	
Нийт				43	-	11	-	47	11	-	27	-	2	-	50	2	-	16	-	9	-	-3	9	11	
Эмнэлгийн эмийн сан																									
1	Аймгийн Нэгдсэн эмнэлэг	Сайншанд сум		1	1	1	4	1	1	1	-	-	1	1	1	1	1	1	1	1	-	3	-	-	
2	Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлэг	Замын-Үүд сум		1	1	1	2	1	1	1	-	-	1	1	1	1	-	1	1	-	1	-	-	1	
3	Зүүнбаянгийн сум дундын эмнэлэг	Сайншанд сум 5 дугаар баг		1	X	X	X	X	X	X	-	X	X	X	X	X	X	1	X	X	X	X	X	X	

“Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудит

4	Уламжлалт анагаах ухааны рашаан сувилалын төв	Сайншанд сум	1	X	X	X	X	X	X	X	X	X	X	X	X	X	1	X	X	X	X	X	X
5	Халзан Уул рашаан сувилал	Даланжаргалан сум		X	X	X	X	X	X	X	X	X	X	X	X	X	-	X	X	X	X	X	X
6	Айраг сумын ЭМТ	Айраг сум	1	X	X	X	X	X	X	X	X	X	X	X	X	X	1	X	X	X	X	X	X
7	Алтанширээ сумын ЭМТ	Алтанширээ сум	1	X	X	X	X	X	X	X	X	X	X	X	X	X	1	X	X	X	X	X	X
8	Даланжаргалан сумын ЭМТ	Даланжаргал сум	1	X	X	X	X	X	X	X	X	X	X	X	X	X	1	X	X	X	X	X	X
9	Дэлгэрэх сумын ЭМТ	Дэлгэрэх сум	1	X	X	X	X	X	X	1	X	X	X	X	X	X	-	X	X	X	X	X	X
10	Ихсэт сумын ЭМТ	Ихсэт сум	1	X	X	X	X	X	X	1	X	X	X	X	X	X	-	X	X	X	X	X	X
11	Мандах сумын ЭМТ	Мандах сум	1	X	X	X	X	X	X	-	X	X	X	X	X	X	1	X	X	X	X	X	X
12	Өргөн сумын ЭМТ	Өргөн сум	1	X	X	X	X	X	X	1	X	X	X	X	X	X	-	X	X	X	X	X	X
13	Сайхандулаан сумын ЭМТ	Сайхандулаан сум	1	X	X	X	X	X	X	-	X	X	X	X	X	X	1	X	X	X	X	X	X
14	Улаанбадрах сумын ЭМТ	Улаанбадрах сум	1	X	X	X	X	X	X	1	X	X	X	X	X	X	-	X	X	X	X	X	X
15	Хатанбулаг сумын ЭМТ	Хатанбулаг сум	1	X	X	X	X	X	X	-	X	X	X	X	X	X	1	X	X	X	X	X	X
16	Хөвсгөл сумын ЭМТ	Хөвсгөл сум	1	X	X	X	X	X	X	-	X	X	X	X	X	X	1	X	X	X	X	X	X
17	Эрдэнэ сумын ЭМТ	Эрдэнэ сум	1	X	X	X	X	X	X	1	X	X	X	X	X	X	-	X	X	X	X	X	X
Нийт			16	2	2	6	2	2	2	5	0	2	2	2	2	1	11	2	0	4	0	0	1
Хувийн эмнэлгийн эмийн сан																							
1	"Ачлал" эмнэлэг	Сайншанд сум	1	X	1	1	1	X	1	-	X	-	-	1	X	-	1	X	1	1	-	X	1
2	"Ач үйлс дэлгэрэх" эмнэлэг	Сайншанд сум	1	X	1	1	1	X	1	-	X	-	-	1	X	-	1	X	1	1	-	X	1
3	"Идэр-Өлзийт" эмнэлэг	Сайншанд сум	1	X	1	1	1	X	1	-	X	-	-	1	X	-	1	X	1	1	-	X	1
4	"Шонхор мед" эмнэлэг	Сайншанд сум	1	X	1	1	1	X	1	-	X	-	-	-	X	-	-	X	-	-	-	X	-
Нийт			4	-	4	4	4	-	4	-	-	-	-	3	-	-	3	-	3	3	-	-	3
Нийт дүн			63	2	17	10	53	13	6	32	0	4	2	55	4	1	30	2	12	7	-3	9	15

Тайлбар: X- Хамааралгүй